| ТШЗ 18.1 | <p>Барааг дагалдах үйлчилгээг хэрэгжүүлэх хүний нөөцийн шаардлага, шалгуур үзүүлэлт: “Шаардана”</p> <ol style="list-style-type: none"> Хүний нөөцийн мэдээллийн баримт бичигт заасан нэр бүхий ажилтан нь тендерт оролцогчийн үндсэн ажилтан байх ба НД-8 маягтын сүүлийн 3 сараар ирүүлэх; |

| | |
|----------|--|
| | <p>2. Захирал, тендерийг хариуцаж төлөөлөх этгээд, нөөцийн хэсгийн эрхлэгч, жор хүлээн авагч эм зүйч, эм найруулагч, инженерүүд зэрэг мэргэжилтний туршлага ур чадвар, боловсрол, мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл, дипломын хуулбар</p> <p>Ижил төстэй бараа нийлүүлсэн туршлагыг нотлох гэрээний туршлага: “Шаардана”</p> <ol style="list-style-type: none"> 1. 2021, 2022, 2023 оны аль нэг жилд тухайн багцын нэр төрөлтэй ижил төстэй барааг нийлүүлж байсан, санал болгож буй үнийн дүнгийн 50 хувиас багагүй үнийн дүнтэй барааг доод тал нь нэг удаа нийлүүлсэн байх; 2. Бараа нийлүүлсэн гэрээний хуулбар, гэрээ дүгнэсэн актын хуулбар, тухайн барааг цаг хугацаанд нь чанартай нийлүүлсэн талаарх захиалагчийн тодорхойлолтыг ирүүлэх. <p>Бараа нийлүүлэхэд ашиглагдах үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгслийн шаардлага: “Шаардана”</p> <p>Тээврийн хэрэгслийн гэрчилгээг ирүүлэх;</p> <p>Түрээсээр тээврийн хэрэгслийг ашигладаг бол түрээсийн гэрээг автомашины фото зургийн хамт ирүүлэх.</p> <p>Оролцогчид тавигдах санхүүгийн чадавхын шалгуур үзүүлэлт, шаардлага:</p> <ol style="list-style-type: none"> 1. Борлуулалтын орлогын хэмжээ: Сүүлийн 2 жилийн (2022, 2023 он) хугацаанд гүйцэтгэсэн нийт борлуулалтын орлогын хэмжээ нь батлагдсан багцын төсвийн 50 хувиас багагүй байх 2. Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: Тухайн багцын батлагдсан төсвийн үнийн дүнгийн 30 хувиас багагүй байна. |
| ТШЗ 18.2 | <p>Тусгай зөвшөөрөл: “Шаардана”. Тусгай зөвшөөрлийн хүчинтэй байх хугацаа нь тендерийн хүчинтэй байх хугацаанд хүчин төгөлдөр байх</p> <ol style="list-style-type: none"> 1. Эм, эмнэлгийн хэрэгсэл ханган нийлүүлэх тусгай зөвшөөрлийг цахимаар шалгана. 2. Үйлдвэрлэгчийн зөвшөөрөл: “шаардлагатай” Үйлдвэрлэгчийн зөвшөөрөл эсвэл гэрээт борлуулагчийн итгэмжлэлийг ирүүлнэ. Гэрээт борлуулагчийн итгэмжлэл гэрчилгээ, гэрээг ирүүлэх /Эх хувийн хуулбарыг баталгаат орчуулгын хамт ирүүлэх. /Хугацаа хүчин төгөлдөр байх/ |
| ТШЗ 19.1 | <p>Санхүүгийн чадавхын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэхийг шаардах эсэх: <u>“Шаардана”</u></p> <ol style="list-style-type: none"> 1. Зээлийн мэдээллийн тухай хуулийн 4.1.5-д заасан зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх этгээдээс тендер шалгаруулалт зарласан өдрөөс хойш авсан, шалгах боломжтой QR код бүхий “Зээлийн мэдээллийн сангийн тодорхойлолт”-ыг ирүүлнэ. Уг тодорхойлолтод төлөгдөж дуусаагүй зээлийн мэдээлэл “Хэвийн” бус байгаа тохиолдолд татгалзах үндэслэл болно. (“Зээлийн мэдээллийн сангийн тодорхойлолт”-ыг www.sainscore.mn, |

| | |
|-----------------|---|
| | <p><i>www.burenscore.mn</i> хаягаар хандан авна. Харилцагч банкны тодорхойлолтыг тендерийг үнэлэхэд харгалзан үзэхгүй.)</p> <ol style="list-style-type: none"> 2. Тендерт оролцогчийн борлуулалтын орлогын мэдээллийг Сангийн яамны санхүүгийн тайлангийн <i>www.e-balance.mof.gov.mn</i> мэдээллийн систем дэх санхүүгийн тайлангаас шалгана. 3. Түргэн хөрвөх хөрөнгийн хэмжээг нийт дүнг дараах шалгуур үзүүлэлтүүдийн аль нэгээр эсвэл нийлбэрээр тодорхойлно. Үүнд: <ul style="list-style-type: none"> - Тендерт оролцогчийн харилцагч банкны дансны үлдэгдэл; - Харилцагч банкнаас авч болох мөнгөн дүн бүхий зээлийн тодорхойлолт /Банкны зээлийн нөхцөлийн дагуу, судлагдаж байгаа болон судалж үзээд зээл олгох боломжтой тухай гэсэн тодорхойлолтыг хүчинтэйд тооцохгүй/ <p>4. Санхүүгийн тайланда хийсэн аудитын дүгнэлт</p> <p>Оролцогчийн санхүүгийн чадавхыг хянан үзэхэд үндэслэл болгох санхүүгийн тайлангийн хугацаа: 2022, 2023 он</p> |
| ТШЗ 20.1 | <p>Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэх эсэх: <u>“Тийм”</u></p> <ul style="list-style-type: none"> - оролцогч өөрөө үйлдвэрлээгүй барааг нийлүүлэхээр санал болгох тохиолдолд уг барааг нийлүүлэх боломжтой болохыг нотлох нийлүүлэгч, үйлдвэрлэгчтэй байгуулсан гэрээ, эсхүл тэдгээрээс энэ тухай гаргасан албан бичиг; - гэрээний үүргийн гүйцэтгэлийг хариуцах ажилтны нэр, боловсрол, мэргэжлийн ур чадварын мэдээлэл; - оролцогчийн туршлагыг харуулах Өгөгдлийн хүснэгтэд заасан хугацаанд гүйцэтгэсэн ижил төстэй бараа нийлүүлсэн, үйлчилгээ үзүүлсэн гэрээний талаар V бүлгийн Маягт 3, Маягт 5-ын дагуу бэлтгэсэн мэдээлэл; - бараа нийлүүлэхэд ашиглахаар Өгөгдлийн хүснэгт болон техникийн тодорхойлолтод заасан үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгслийн мэдээлэл, тэдгээрийг цаг хугацаанд нь (өөрийн өмчлөл, эзэмшилийн, түрээслэх гэх мэт) бэлэн байлгах санал; - техникийн чадавх болон туршлагын талаар ТШЗ-ны 16.1-д заасан шалгуур үзүүлэлт, шаардлагыг хангаж буйг нотлох Өгөгдлийн хүснэгтэд заасан бусад баримт. <p>-Маягт ТШМ-1 дагуу үнийн санал баталгаажуулан ирүүлэх;</p> <p>- Техникийн тодорхойлолтын харьцуулалт /Техникийн тодорхойлолтыг үндсэн дээж, каталогтой харьцуулах бөгөөд зөрсөн тохиолдолд татгалзах үндэслэл болно/</p> <p>-Бараа нийлүүлэлтийн хуваарийг баталгаажуулж ирүүлэх.</p> <p>- Тендерт оролцож шалгарсан ханган нийлүүлэх байгууллагууд нь шалгарсан эм, эмнэлгийн хэрэгслийг танилцуулах, гардан үйлдэл хийх практик сургалтыг гадаад, дотоодод зохион байгуулах тухайг албан бичгээр ирүүлнэ.</p> <p>-Тендерт оролцогч нь татвар, банк, нийгмийн даатгалын хэлтэс, шүүх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар болон холбогдох эрх бүхий байгууллагуудаас тодруулга авахад татгалзах зүйлгүй тухай албан бичиг ирүүлэх;</p> <p>-Тендерт шалгарсан тохиолдолд гэрээний үнэ болон хугацаанд багтаан чанарын</p> |

| | <p>шаардлага хангасан барааг захиалагчид нийлүүлэх баталгааг албан бичгээр гаргаж ирүүлэх;</p> <p>-Хэрэв барааг гэрээний хугацаанд нийлүүлэх боломжгүй болсон тохиолдолд бусад эм ханган нийлүүлэх байгууллагаас тендерт ирүүлсэн үнийн саналаар эм, эмнэлгийн хэрэгслийг захиалагчид тасралтгүй нийлүүлэх баталгааг албан бичгээр ирүүлэх;</p> <p>Багаж хэрэгслийн чанар захиалагчийн техникийн тодорхойлолтыг хангахгүй, болон сав баглаа боодол гэмтсэн, хагарсан, асгарсан гэмтэл үссэн тохиолдолд өөрийн зардлаар сольж өгөх албан бичиг ирүүлэх;</p> <p>- Тусгай зориулалтын агуулахтай байх ба түүнийг нотлох баримт бичиг ирүүлэх /зураг, танилцуулга/;</p> <p>Дээрх шаардсан баримт бичгийн аль нэгийг ирүүлээгүй тохиолдолд тендерээс татгалзах үндэслэл болно.</p> <p>Мөн ТӨХ-д шаардагдаагүй үнэлгээнд нөлөөлөхүүц бус баримт бичгийг нэмэлтээр ирүүлсэн тохиолдолд үнэлгээнд харгалзахгүй болно.</p> <p>Оролцогч, түүний түншлэлийн гишүүдийн хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэх эрх авсан гэрээний талаарх мэдээлэл: “Шаардахгүй”</p> | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | |
|-----------|--|------------------------|---------------------|------------------------|---------------------|----|--|-------------|---------|----|---|-------------|---------|----|---------------------------|-------------|---------|----|--|-------------|-----------|----|---------------------------|-------------|-------------|----|---|---------------|-----------|----|---|-------------|-----------|----|--|-------------|-----------|----|--|-------------|-----------|
| ТШЗ 21.5. | Оролцогчийн санал болгосон үнийг гэрээний хэрэгжилтийн явцад: “Тохируулахгүй тогтмол байна” | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | |
| ТШЗ 21.6 | Олон улсын худалдааны нөхцөлийг хэрэглэх эсэх: “Тийм”. Incoterms 2020, DDP Улаанбаатар. | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | |
| ТШЗ 24.1 | <p>Тендерийн баталгааны дүн: Тухайн багцын батлагдсан төсөвт өртөг 100 сая төгрөгөөс давсан бол тендерийн баталгааг 0.5 хувиар тооцож ирүүлнэ.</p> <p>Дараахь багцад тендер ирүүлэх оролцогч тендерийн баталгаа заавал ирүүлнэ.Үүнд:</p> <table border="1"> <thead> <tr> <th></th> <th>Багцын нэрс</th> <th>Багцын нийт дүн</th> <th>Хувилсан дүн</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>1.</td> <td>Багц 1. Дурангийн мэс заслын хэрэгсэл/ трокар/</td> <td>139,615,000</td> <td>698,075</td> </tr> <tr> <td>2.</td> <td>Багц 5. Биполяр болон хэт авиан энэргиэр эдийг түлж тайрах хэрэгсэл</td> <td>132,000,000</td> <td>660,000</td> </tr> <tr> <td>3.</td> <td>Багц 9. Мэс заслын оёгч-3</td> <td>172,875,000</td> <td>864,375</td> </tr> <tr> <td>4.</td> <td>Багц 10. Өндөр давтамжаар түлж тайрах нэг удаагийн гар</td> <td>202,400,000</td> <td>1,012,000</td> </tr> <tr> <td>5.</td> <td>Багц 17. Урологи Хармоник</td> <td>124,078,878</td> <td>620,394.039</td> </tr> <tr> <td>6.</td> <td>Багц 20. Мэдрэлийн судасны оношлогоо болон эмчилгээний хэрэгсэл</td> <td>1,433,090,000</td> <td>7,165,450</td> </tr> <tr> <td>7.</td> <td>Багц 21. Мэдрэлийн судасны оношлогоо болон эмчилгээний хэрэгсэл 3</td> <td>220,850,000</td> <td>1,104,250</td> </tr> <tr> <td>8.</td> <td>Багц 23. Элэгний ангиографийн оношлогоо эмчилгээний хэрэгсэл</td> <td>767,175,000</td> <td>3,835,875</td> </tr> <tr> <td>9.</td> <td>Багц 25. Хэвллийн хөндийн оношлогоо эмчилгээний хэрэгсэл</td> <td>219,450,000</td> <td>1,097,250</td> </tr> </tbody> </table> | | Багцын нэрс | Багцын нийт дүн | Хувилсан дүн | 1. | Багц 1. Дурангийн мэс заслын хэрэгсэл/ трокар/ | 139,615,000 | 698,075 | 2. | Багц 5. Биполяр болон хэт авиан энэргиэр эдийг түлж тайрах хэрэгсэл | 132,000,000 | 660,000 | 3. | Багц 9. Мэс заслын оёгч-3 | 172,875,000 | 864,375 | 4. | Багц 10. Өндөр давтамжаар түлж тайрах нэг удаагийн гар | 202,400,000 | 1,012,000 | 5. | Багц 17. Урологи Хармоник | 124,078,878 | 620,394.039 | 6. | Багц 20. Мэдрэлийн судасны оношлогоо болон эмчилгээний хэрэгсэл | 1,433,090,000 | 7,165,450 | 7. | Багц 21. Мэдрэлийн судасны оношлогоо болон эмчилгээний хэрэгсэл 3 | 220,850,000 | 1,104,250 | 8. | Багц 23. Элэгний ангиографийн оношлогоо эмчилгээний хэрэгсэл | 767,175,000 | 3,835,875 | 9. | Багц 25. Хэвллийн хөндийн оношлогоо эмчилгээний хэрэгсэл | 219,450,000 | 1,097,250 |
| | Багцын нэрс | Багцын нийт дүн | Хувилсан дүн | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | |
| 1. | Багц 1. Дурангийн мэс заслын хэрэгсэл/ трокар/ | 139,615,000 | 698,075 | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | |
| 2. | Багц 5. Биполяр болон хэт авиан энэргиэр эдийг түлж тайрах хэрэгсэл | 132,000,000 | 660,000 | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | |
| 3. | Багц 9. Мэс заслын оёгч-3 | 172,875,000 | 864,375 | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | |
| 4. | Багц 10. Өндөр давтамжаар түлж тайрах нэг удаагийн гар | 202,400,000 | 1,012,000 | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | |
| 5. | Багц 17. Урологи Хармоник | 124,078,878 | 620,394.039 | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | |
| 6. | Багц 20. Мэдрэлийн судасны оношлогоо болон эмчилгээний хэрэгсэл | 1,433,090,000 | 7,165,450 | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | |
| 7. | Багц 21. Мэдрэлийн судасны оношлогоо болон эмчилгээний хэрэгсэл 3 | 220,850,000 | 1,104,250 | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | |
| 8. | Багц 23. Элэгний ангиографийн оношлогоо эмчилгээний хэрэгсэл | 767,175,000 | 3,835,875 | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | |
| 9. | Багц 25. Хэвллийн хөндийн оношлогоо эмчилгээний хэрэгсэл | 219,450,000 | 1,097,250 | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | |

| | | | | |
|--|-----|---|-------------|--------------|
| | 10. | Багц 26. Судас бөглөгч | 128,500,000 | 642,500 |
| | 11. | Багц 30. Иод агуулсан тосон сууртай бөглөгч бодис | 450,000,000 | 2,250,000 |
| | 12. | Багц 31. Өндөр давтамжит түлэх эмчилгээний зүү | 220,000,000 | 1,100,000 |
| | 13. | Багц 34. Пейсмекер -1 | 122,373,900 | 611,869.5 |
| | 14. | Багц 36 Зүрхэн доторх оношилгоо эмчилгээ-2 | 211,110,000 | 1,055,550 |
| | 15. | Багц 37. Пейсмекер-2 | 122,373,900 | 611,869.5 |
| | 16. | Багц 40. Өвдөгний хиймэл үе | 769,241,036 | 3,846,205.18 |
| | 17. | Багц 41. Түнхний хиймэл үе | 200,531,558 | 1,002,657.79 |
| | 18. | Багц 53. Мэдрэлийн мэс засал-2 | 139,589,571 | 697,947,855 |
| | 19. | Багц 57. ЧХХ- Хэрэгсэл-1 | 130,493,000 | 652,465 |
| | 20. | Багц 59. ЧХХ- Суулгац | 462,200,000 | 2,311,000 |
| | 21. | Багц 67. Зүрхэн доторх оношилгоо эмчилгээ-1 | 413,090,000 | 2,065,450 |
| | 22. | Багц 69. Хоол боловсруулах замын цус алдалтыг тогтоох, хавдар хөнгөвчлөх хэрэгслүүд | 109,749,600 | 548,748 |

Хүчинтэй байх хугацаа: **Тендерийн хүчинтэй байх хугацаанаас хойш 28 хоногийн хугацаанд хүчинтэй байна.**

Анхааруулга: Цахим тендерт оролцогч тендерийн материалд цахим тендерийн баталгааг хавсарган ирүүлэх шаардлагагүй бөгөөд цахим системээр дамжуулан гаргасан цахим тендерийн баталгааны мэдээлэл үнэн зөв эсэхийг шалгах, нягтлах үүрэгтэйг анхаарна уу.

Г. ТЕНДЕР ИЛГЭЭХ, НЭЭХ

| | |
|-----------|--|
| ТШЗ 25.5. | Оролцогчдод ил болох баримт бичгийн жагсаалт: Тендерт оролцогч нь Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь файл үүсгэн ирүүлнэ. Тус файлын эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн эрх бүхий этгээд баталгаажуулан ирүүлнэ. Нууцалсан баримт бичиг, мэдээллийн жагсаалтыг Маягт 6-ын дагуу ирүүлнэ. |
| ТШЗ 26.1. | Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь: Огноо: 2024 оны 05 дугаар сарын 30-ны өдөр |

| | |
|------------------|--|
| | Цаг: 10 өдөр |
| ТШЗ 26.2. | <p>Тендерийн нээлтийг доор дурдсан хугацаанд цахим системээр хийх бөгөөд нээлтийн мэдээллийг оролцогч цахим системээр хүлээн авна.</p> <p>Огноо: [2024 оны 05 дугаар сарын 30-ны өдөр]</p> <p>Цаг: [11 цаг 00 минут]</p> <p>Тендерийн нээлтэд тендерт оролцогчийн төлөөлөгч биечлэн оролцох боломжтой газрын хаяг: Баянзүрх дүүрэг, 3-р хороо, Энхтайваныгудамж-49, Улсын хоёрдугаар төв эмнэлэг, УОЭТөв байр, 2 давхарын хурлын заал</p> |

Д. ЗАХИАЛАГЧ ШИЙДВЭР ГАРГАХ

| | |
|------------------|---|
| ТШЗ 29.2. | Тендер үнэлэх үндсэн шалгуурыг нь хуулийн 11.8, 27.6-д заасан чанар ба үнийн хосолмол шалгуурыг хэрэглэнэ. |
| ТШЗ 31.1. | <p>Давуу эрх тооцуулахад шаардлагатай мэдээлэл, баримт бичиг:</p> <p>Хуулийн 8 дугаар зүйлд заасан үндэслэлээр давуу эрх тооцуулахыг хүссэн тендерт оролцогч давуу эрх эдлэх хүсэлтийн бол албан бичиг, барааны жагсаалт, давуу эрх тооцуулахтай холбогдох нотлох баримтыг ирүүлнэ.</p> |
| ТШЗ 32.1 | Үнэлгээнд харгалзах нэмэлт шалгуур үзүүлэлт ашиглах эсэх: “Ашиглахгүй” |

III БҮЛЭГ. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ, ТАВИГДАХ ШААРДЛАГА

[Захиалагч болон үнэлгээний хороо нь худалдан авах барааны техникийн тодорхойлолтыг боловсруулахад энэхүү санамжийг ашиглана.

Техникийн тодорхойлолтын зорилго нь захиалагчид шаардлагатай барааг нарийвчлан тодорхойлоход оршино. Уг санамж нь хэм хэмжээ тогтоохгүй ба захиалагчаас батлах тендер шалгаруулалтын баримт бичгийн хэсэг болохгүй.

- Ойлгомжтой сайтар бэлтгэсэн техникийн тодорхойлолт нь захиалагчийн тавьсан шаардлагад нийцсэн, бодитой бөгөөд өрсөлдөх чадвартай тендер бэлтгэхэд оролцогчдод зайлшигүй чухал нөхцөл болно.
- Техникийн тодорхойлолтыг бэлтгэхэд өрсөлдөөнийг өрнүүлэх зарчмыг баримтлах ёстой бөгөөд худалдан авах барааны шинж чанар, материал, үйл ажиллагааны шаардлагдах стандартын талаар тодорхой тусгана. Эдгээрийг хангасан нөхцөлд худалдан авах ажиллагааны хэмнэлттэй, үр ашигтай, шударга байх зорилго хэрэгжиж, тендерүүдийн шаардлагад нийцэх байдал баталгаажиж, тендерийн үнэлгээ зөв хийгдэнэ.
- Техникийн тодорхойлолт боловсруулахдаа батлагдсан төсөөт багтаан эрчим хүч, байгалийн нөөцийн хэмнэлттэй, эдийн засгийн үр ашигтай хэрэглээний тогтвортой байдлыг хангах, байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй, хүлэмжийн хийн ялгарал болон хаягдал багатай, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, ногоон орчныг бүрдүүлэхэд чиглэсэн байх үзүүлэлтийг тусгаж өгнө.
- Тендер шалгаруулалтын баримт бичигт зааснаас бусад тохиолдолд бух бараа, материал нь шинэ, ашиглаадаагүй, сүүлийн үеийн технологи зэргийг хангасан байх нөхцөлийг шаардана. Өмнө хэрэгжсэн, ижил төстэй төслийн техникийн тодорхойлолтыг жишээ болгон ашиглах нь давуу талтай.
- Техникийн тодорхойлолтын шалгуур үзүүлэлтүүд нь хязгаарласан шинжтэй байж болохгүй. Барааны тэмдэг, нэр, хэлбэр маяг, төрөл, гарал үүсэл, үйлдвэрлэлийн арга, үйлдвэрлэгч буюу нийлүүлэгчийг тухайлан заасан шаардлага, нөхцөлийг заах шаардлагатай бол түүний ард “эсхүл түүнтэй дүйцэх” гэсэн тодотгол хэрэглэнэ.
- Бараа материалын, техникийн тодорхойлолтод аль болох олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн стандартыг хэрэглэх шаардлагатай. Хэрэв Монгол Улсын үндэсний стандарт, эсхүл тухайлсан өөр стандартыг хэрэглэсэн тохиолдолд бараа материал, шинж чанар нь энэ стандартад дүйцэх буюу түүнээс илүү бол хүлээн зөвшөөрнө гэж техникийн тодорхойлолтод заах хэрэгтэй.

Зураг, төсөл

Шаардлагатай бол барааны эскиз, зургийг хавсаргана.

Шалгалт, туршилт

[Захиалагч оролцогчоос нийлүүлэх гэж буй бараанд үйлдвэрийн болон бусад шалгалт, туршилт хийсэн болохыг нотлох баримт, үүнтэй холбоотой мэдээлэл ирүүлэхийг шаардаж болно.

Шаардлагатай тохиолдолд захиалагч загвар, дээжийг шалгаж, туршиж болох ба шалгалт, туршилт хийсний үр дүнд тухайн загвар, дээжийн үндсэн шинж чанар алдагдсан, зориулалтын дагуу дахин ашиглах боломжгүй болсон тохиолдолд оролцогчид буцааж олгохгүй тухай техникийн тодорхойлолтод заана. Бусад тохиолдолд гэрээ байгуулсны дараа шалгарсан оролцогчийн загвар, дээжээс бусад загвар, дээжийг буцааж олгоно.

Загвар, дээжийг хэрхэн шалгах, турших тухай тодорхой заана.]

Техникийн тодорхойлолт

Нийлүүлэх бараа нь доор дурдсан техникийн тодорхойлолт, стандартад нийцсэн байна.

Барааны нэр:

| № | Захиалагчийн техникийн тодорхойлолт <i>(Тухайн барааны үзүүлэлт тус бүрийг дор жагсааж бичих ба хэрвээ чанарын баталгаат хугацаа шаардах бол бичнэ үү.)</i> | Санал болгож буй техникийн тодорхойлолт <i>(захиалагчийн техникийн тодорхойлолтыг хуулахгүй байхыг анхаарна уу. Зөвхөн санал болгож буй барааны техникийн тодорхойлолтыг бичнэ үү.)</i> | Тайлбар <i>(дээрх үзүүлэлтийг нотлох баримт бичиг болон танилцуулгыг хавсаргана)</i> |
|-----|--|--|---|
| 1 | | | |
| 2 | | | |
| 3 | | | |
| ... | | | |

[Үнэлгээний хороо худалдан авах ажиллагааны цахим систем [/www.tender.gov.mn/-д нийтэлсэн техникийн тодорхойлолтын жишиг нөхцөл, стандарт, загварыг баримтлан техникийн тодорхойлолтыг боловсруулна.\]](http://www.tender.gov.mn/)

Бараа нийлүүлэлтийн хуваарь

[Захиалагч доорх хүснэгтийн 1-6 хүртэлх баганыг, төндөрт оролцогч 7 дугаар баганыг бөглөнө]

| № | Барааны нэр | Тоо хэмжээ | Хэмжих нэгж, тун | Өгөгдлийн хүснэгтэд заасан барааг хүргэх эцсийн цэг | Бараа нийлүүлэх хугацаа | |
|-----|---------------------------|---------------------------------------|------------------------------|---|--|--|
| | | | | | Захиалагч бараа хүлээн авах хугацаа (эхлэх болон дуусах хугацаа) | Нийлүүлэгчийн санал болгох хугацаа (Оролцогч энэ баганыг бөглөнө) |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1 | [Барааны нэрийг бичих] | [Нэгжийн тоо ширхгийг бичих] | [Хэмжих нэгжийг бичих] | [Бараа хүргэх газрын нэр] | [Гэрээ байгуулснаас хойш нийлүүлэх хугацаа бич. Жишээ нь: 2023.10.01-ээс 2023.10.14] | [6 дугаар баганад заасан хугацаанд багтаан нийлүүлэхээр санал болгож буй хугацааг бичих] |
| 2 | | | | | | |
| 3 | | | | | | |
| ... | | | | | | |

**IV БҮЛЭГ. ТЕНДЕРИЙГ ҮНЭЛЭХ ҮНДСЭН ШАЛГУУР ҮНЭЛГЭЭНД ХАРГАЛЗАХ
НЭМЭЛТ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД**

IV.1.Тендерийг үнэлэх “Чанар ба үнийн хосолмол” үндсэн шалгуур

1. Эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авах чанар ба үнийн хосолмол шалгуур (*Эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авах тендер шалгаруулалтаас бусад тендер шалгаруулалтад тус тендер үнэлэх үндсэн шалгуурыг тендер шалгаруулалтын баримт бичгээс хасна*)

1. Эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авах тендер шалгаруулалтын үед хамгийн бага харьцуулах үнэ (P_{min})-тэй тендерт 30 оноо (S_{max}) өгч, бусад оролцогчийн харьцуулах үнэ (P_x)-д харгалзах оноог дараах томьёогоор бодно.

$$S_x = \frac{P_{min}}{P_x} \cdot S_{max}$$

P_{min} -Хамгийн бага харьцуулах үнэтэй оролцогчийн үнэ

P_x - Тухайн оролцогчийн үнэ

S_x - Тухайн оролцогчийн оноо

S_{max} -Хамгийн бага харьцуулах үнэтэй оролцогчийн оноо

2. Эмийн чанарын үнэлгээг дараах шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлнэ:

- | | |
|--|--------|
| 2.1. Эм нь Дэлхийн эрүүл мэндийн байгууллага (ДЭМБ)-ын урьдчилан баталгаажуулалтад орсон бол: | 8 оноо |
| 2.2. ДЭМБ-ын эмийн зохицуулалтын төлөвшлийн түвшингээр 4-т жагссан улсад үйлдвэрлэгдсэн бол | 8 оноо |
| 2.3. Эм нь хатуу зохицуулалттай улсад үйлдвэрлэгдсэн бол (SRA, PICS): | 8 оноо |
| 2.4. Импортын эм нь үйлдвэрлэгч улсад хэрэглэдэг бол (чөлөөт худалдааны гэрчилгээ) | 6 оноо |
| 2.5. Ерөнхий нэрилийн эмийн хувьд биоэквивалент чанарын судалгааг хөндлөнгийн эрх бүхий судалгааны байгууллагаар хийлгэсэн бол (Цусан дахь эмийн идэвхт бодисын хамгийн их концентраци (S_{max}) 80 -125%) | 6 оноо |
| 2.6. Үйлдвэрлэгч нь ДЭМБ-ын эм үйлдвэрлэлийн зохистой дадал (GMP) хангасан гэрчилгээтэй бол | 6 оноо |
| 2.7. Эм нь итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээнд хамрагдсан бол | 4 оноо |
| 2.8. Эм нь Англи, АНУ, Европ, Япон, БНХАУ, ОХУ-ын фармаколойн шаардлага хангасан нотлох баримт ирүүлсэн бол | 4 оноо |
| 2.9. Эм нь АНУ-ын бүртгэлтэй эмийн жагсаалт “Orange Book”-д орсон бол | 4 оноо |
| 2.10. Эм нь ДЭМБ-ын харьцуулах бүтээгдэхүүний жагсаалтад орсон бол | 4 оноо |
| 2.11. Анхдагч буюу оригинал эм бол | 4 оноо |

| | |
|--|---------|
| 2.12. Ханган нийлүүлэгч нь өөрөө импортлогч бол | 4 оноо |
| 2.13. Тухайн эм нь сүүлийн нэг жилд лабораторийн шинжилгээгээр стандарт бус гаралагч бол | 2 оноо |
| 2.14. Эмийн аюулгүй байдлын хугацаат тайланг (PSUR) сүүлийн 2 жилийн хугацаанд эмийн зохицуулалтын байгууллагад мэдээлсэн бол | 2 оноо |
| Нийт | 70 оноо |
| 3. Эмнэлгийн хэрэгслийн чанарын үнэлгээг дараах шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлнэ: | |
| 3.1. Үйлдвэрлэгч нь ISO 13485 стандартын шаардлага хангасан бол | 15 оноо |
| 3.2. Импортын эмнэлгийн хэрэгсэл нь үйлдвэрлэгч улсдаа хэрэглэдэг бол (FREE SALE CERTIFICATE) | 15 оноо |
| 3.3. Эмнэлгийн хэрэгсэл нь гурав ба түүнээс дээш улсад нийлүүлэгддэг бол | 15 оноо |
| 3.4. Үйлдвэрлэгч нь үйлдвэрлэлийн сайн дадал (Good manufacturing practice) гэрчилгээтэй бол | 15 оноо |
| 3.5. Үйлдвэрлэгч нь ISO 9001 стандартын шаардлага хангасан бол | 10 оноо |
| Нийт | 70 |
| 4. Чанар ба үнийн хосолмол үнэлгээний шалгуурт нийт оноог дээрх аргачлалын дагуу тооцох ба харьцуулах үнэ болон чанарын үнэлгээнд харгалзах онооны нийлбэрээр хамгийн өндөр оноотой тендерийг хамгийн сайн тендер гэж үзнэ. | |

$$B_x = Q_x + S_x$$

Bx – Тухайн оролцогчийн чанар ба үнэлгээний харьцуулалтын нийт оноо

Qx – Тухайн оролцогчийн чанарын үнэлгээний оноо

IV.2. Үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлт

Өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 29.1-д үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлт ашиглахаар заасан бол захиалагч тендерийн үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлтийг үлдээж бусад шалгуур үзүүлэлтийг хасна.

Энэ бүлэг нь ТШЗ-ны зүйл бөгөөд захиалагч өгөгдлийн хүснэгтэд тусгайлсан зөвшөөрсөн бол тендерийн үнэлгээ хийхэд тендерийн маягтад тусгасан үнийн саналаас гадна энэ хэсэгт заасан нэг буюу хэд хэдэн шалгуур үзүүлэлтийг мөнгөөр илэрхийлэн, тендерийн үнийг хийсвэрээр нэмэгдүүлэх замаар тендерийн харьцуулах үнийг тодорхойлон үнэлгээ хийх зорилгоор ашиглана.

Захиалагч энэ хэсэгт зааснаас өөр шалгуур үзүүлэлтийг үнэлгээнд харгалзахгүй.

- Бараа хүргэх, ажил, үйлчилгээ дуусгах хугацаа: “Ашиглахгүй

Хэрэв “ашиглах” бол: Тухайн тендер шалгаруулалтад холбогдох гэрээний дагуу гүйцэтгэх хуваарьт заасан зөвшөөрөгдөх хугацааны хооронд (гэрээний үргийн гүйцэтгэлийг эхлэх эхний өдрөөс хойш үүрэг гүйцэтгэвэл зохих сүүлчийн өдрийг оролцуулан) гэрээний үргийг хэрэгжүүлсэн байх шаардлагатай. Захиалагчийн заасан гэрээний үүрэг гүйцэтгэх хугацаанаас өмнө гүйцэтгэх санал ирүүлсэн тендерт урамшуулал, эсхүл үнэлгээнд бусад тендерээс давуу нөхцөл олгохгүй.

Захиалагч уг шалгуур үзүүлэлтийг үнэлгээнд ашиглахаар тусгайлан зөвшөөрсөн тохиолдолд захиалагчаас заасан гэрээний гүйцэтгэлийн хуваарьт зааснаас хоцорч гүйцэтгэхээр санал болгосон тендерээс татгалзахгүй ба үнэлгээнд харгалзах зорилгоор хоцорсон хоног тутамд [хувь бичих]–аар тооцож тендерийн харьцуулах үнэ дээр нэмнэ.

Захиалагчаас заасан гэрээний гүйцэтгэлийн хуваарьт зааснаас [тоо бичих]–аас илүү [“cap”, “өдөр” гэдэг үгнээс сонгож бичих] хоцроож гүйцэтгэх санал болгосон тендерээс татгалзана. Харин өгөгдлийн хүснэгтэд тусгайлан зөвшөөрөгүй тохиолдолд захиалагчийн тогтоосон гүйцэтгэлийн хуваариас хойш гүйцэтгэх санал ирүүлсэн тендерийг шаардлагад нийцээгүй гэж үзнэ.

2. Бараа, ажил, үйлчилгээний гэрээний гүйцэтгэлийн дараах үйлчилгээг захиалагчийн заасан газар үзүүлэх боломж: “Ашиглахгүй”

Хэрэв “ашиглах” бол урсгал засвар үйлчилгээний цэг бий болгох болон үндсэн/шаардлагатай сэлбэг хэрэгслээр хангахын тулд захиалагчид шаардагдах зардлыг тусад нь үнэлж ирүүлсэн бол түүнийг үнэлгээний зорилгоор тендерийн харьцуулах үнэ дээр нэмж үнэлнэ.

3. Байгаль орчинд нөлөөлөх байдал: “Ашиглахгүй”

Гэрээний гүйцэтгэлийн явцад байгаль орчинд нөлөөлөх байдалтай холбоотой дараах үзүүлэлтийг үнэлгээнд харгалзан үзэж, тендерийн харьцуулах үнэ дээр хийсвэрээр нэмж үнэлнэ. [Захиалагч харгалзан үзэх шалгуур үзүүлэлт, түүнд хамаарах утгыг доор жагсааж бичих.]

4. Хуульд нийцсэн бусад шалгуур үзүүлэлт: “Ашиглахгүй”

Гэрээний гүйцэтгэлд хамаарах хуульд нийцсэн дараах үзүүлэлтийг үнэлгээнд харгалзан үзэж, тендерийн харьцуулах үнэ дээр хийсвэрээр нэмж үнэлнэ. [Захиалагч харгалзан үзэх шалгуур үзүүлэлт, түүнд хамаарах утгыг доор жагсааж бичих.]

Тухайлбал хуулийн 12.3-т заасныг үндэслэн тендерийн үнэлгээнд эрчим хүч, байгалийн нөөцийн хэмнэлттэй, эдийн засгийн үр ашигтай хэрэглээний тогтвортой байдлыг хангах, байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй, хүлэмжийн хийн ялгарал болон хаягдал багатай, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, ногоон орчныг бүрдүүлэхэд чиглэсэн бараа нийлүүлэх тендерийн харьцуулах үнийг дараах байдлаар тодорхойлж болно.

Жишээ нь: А4 бичгийн цаас худалдан авах үнэлгээний шалгуур үзүүлэлт

| № | Шалгуур үзүүлэлт | Үнэлгээ |
|------------|--|-------------------------------|
| I | Нийгмийн шалгуур | Хамгийн их оноо (-5%) |
| 1.1 | Олон улсын хөдөлмөрийн стандарт, ОУХБ-ын Суурь конвенцыг дагаж мөрдөж буй байдал | |
| 1.2 | Ажиллах хүч / ажил эрхлэлтийн харилцаа | |
| 1.3 | Ажиллагсдын нийгмийн болон эрүүл мэндийн даатгал | |
| 1.4 | Шударга цалин хөлс болон хөдөлмөрийн харилцаа | |
| 1.5 | Ажиллах орчны аюулгүй байдал | |
| 1.6 | Нийгмээс тусгаарлагдсан хүмүүсийн ажил эрхлэлт | |
| II | Эдийн засгийн шалгуур | Хамгийн их оноо (-5%) |
| 2.1 | Бизнесийн ёс зүй (Ёс зүйн код) | |
| 2.2 | Орон нутгийн эдийн засагт үзүүлж буй дэмжлэг | |
| 2.3 | Тээвэрлэлт/хүргэлт | |
| 2.4 | Хаяж устгах (Биетээр татан авах эсвэл аюулгүй байдлаар устгах) | |
| III | Байгаль орчны тогтвортой байдлын шалгуур | Хамгийн их оноо (-10%) |
| 3.1 | Байгаль орчны хууль тогтоомж дагаж мөрдөж буй байдал (ISO 14001) | |
| 3.2 | Компанийн чанарын удирдлагын тогтолцоо (ISO 9001) | |
| 3.3 | Таримал ойгоос бэлтгэсэн, эсхүл дахин боловсруулсан цаас | |
| 3.4 | Энгийн хлор агуулаагүй | |
| 3.5 | Цайралт | |
| 3.6 | Байгаль орчинд ээлтэй савлагаа | |
| 3.7 | Дахин боловсруулах боломжтой | |

Дээрх үнэлгээний шалгуур үзүүлэлт дээр үндэслэн тендерт оролцогчийн санал болгож буй үнийг (-20) хувь хүртэл нэмэгдүүлж харьцуулах үнийг тодорхойлно. Уг үнэ нь зөвхөн харьцуулах зорилготой. Тогтвортой худалдан авах ажиллагааны шалгуур үзүүлэлтийн талаар Төрийн тогтвортой худалдан авах ажиллагааны гарын авлага (МУСЯ, НҮББОХ, 2018)-аас танилцах боломжтой.

V БҮЛЭГ. ТЕНДЕРИЙН ЖИШИГ МАЯГТУУД

Маягт 1. Тендер илгээх маягт

Маягт 2. Барааны үнийн задаргаа

Маягт 3. Ижил төстэй бараа нийлүүлсэн гэрээний мэдээлэл

Маягт 4. Хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэхээр эрх авсан гэрээний мэдээлэл

Маягт 5. Ижил төстэй гэрээний дэлгэрэнгүй мэдээлэл

Маягт 6. Нууцалсан баримт бичиг, мэдээллийн жагсаалт

Маягт 1 Тендер илгээх маягт

[огноо]

[Захиалагч байгууллагын нэр]-д

Манай [оролцогчийн нэр] нь танай байгууллагаас зарласан [тендер шалгаруулалтын нэр, дугаар] тендер шалгаруулалтад [үнийн хөнгөлөлт тооцоогүй тендерийн үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр тендер шалгаруулалтын баримт бичигт заасан хуваарийн дагуу бараа нийлүүлэхээр, дор дурдсан нөхцөлийг баталж энэхүү тендер (цаашид “тендер” гэх)-ийг хүргүүлж байна. Үүнд:

1. Тендер шалгаруулалтын баримт бичиг, түүнд заасан гэрээний нөхцөл (гэрээний ерөнхий нөхцөл, тусгай нөхцөл, гэрээ баталгаажуулах маягт)-тэй танилцаж, бүрэн хүлээн зөвшөөрч тендер шалгаруулалтад оролцсон.
2. Оролцогч, түүний түншлэлийн гишүүн худалдан авах ажиллагаанд оролцохтой холбоотой хуулиар хориглосон нөхцөлд хамаarahгүй бөгөөд үүний дотор дараах нөхцөлийг гэрчилж байна. Үүнд:
 - 2.1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7.1-д заасан нөхцөл үүсээгүй;
 - 2.2. Нөлөө бүхий хувьцаа эзэмшигч, түүний эцсийн өмчлөгч, хөрөнгө эзэмшигч, хамтрагч, эсхүл эдгээрийг гүйцэтгэж байгаа хувиараа аж ахуй эрхлэгч нь Нийтийн албанад нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 20.2 дахь хэсэгт заасан албан тушаал эрхэлж байсан болон эрхэлж байгаа хүн, эсхүл түүнтэй хамаарал бүхий этгээд биш;
 - 2.3. Захиалагчийн удирдлага, хяналт, захиргаанд ажилладаг албан тушаалтанд ашиг олгодоггүй;
 - 2.4. Оролцогчийг төлөөлж буй этгээд нь Нийтийн албанад нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 21.1.3 дахь заалтад заасан хязгаарлалтад хамаarahгүй.
3. Тендертэй холбоотой нотлох баримт, мэдээллийг холбогдох этгээдээс гаргуулах эрхийг захиалагчид үүгээр олгож байна.
4. Тендерт үнийн хөнгөлөлт [“санал болгоно” эсхүл “санал болгохгүй” гэж бичих]. [Хэрэв үнийн хөнгөлөлт санал болгох бол түүнийг хэрхэн хэрэглэх нөхцөл, аргачлалыг бичих].
5. Тендер нь тендер шалгаруулалтын баримт бичигт заасны дагуу тендер нээснээс хойш [ажлын 30 ба түүнээс дээш хоногийн тоо] хоногийн хугацаанд хүчинтэй байна.¹
6. Хуулийн 7.1, 22.2, 56.5-д заасныг зөрчсөн болон тендер шалгаруулалтад үнэн зөв, зөрүүгүй орчуулга ирүүлэх үүргээ зөрчсөн тендер шалгаруулалтад оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн жагсаалтад бүртгэх үндэслэл болохыг хүлээн зөвшөөрч байна.
7. Тендерт санал болгосон бараа нь оюуны өмчийн зөрчилгүй, эрхийн болон биет байдлын доголдолгүй болохыг баталж байна.
8. Тендерийг холбогдох журмын дагуу бусад оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч, тендерийг нууцлах аливаа үүргээс захиалагчийг бүрэн чөлөөлж байна.

¹ Хэрэв тендер шалгаруулалт нь урьдчилсан худалдан авах ажиллагааны журмаар зохион байгуулагдах бол “5. Тендер нь тендер шалгаруулалтын баримт бичигт зааснаар хугацаагүй хүчинтэй байна.” гэж сольж бичнэ үү.

*[Итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд,
эсхүл түүнээс эрх олгогдсон этгээдийн нэр,
албан тушаал, гарын үсэг,
байгууллагын тамга, тэмдэг]:*

Хаяг:

Маягт 2 Барааны үнийн задаргаа

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 |
|-----|-------------|--------------------------------------|---------------|------------------------|-------------|--|--|---|--|---|
| № | Барааны нэр | Гарал үүслийн улс ² | Тоо хэмжээ | Хэмжих нэгж, тун | Нэгж үнэ | Нэр төрөл бүрийн бүгд үнэ (4x6) | Барааг эцсийн цэгт хүргэхэд шаардагдах дотоодын тээвэрлэлт болон бусад үйлчилгээний үнэ | Бараа нийлүүлэхэд ногдох татвар, хураамж | Нэр төрөл бүрийн нийт үнэ (7+8+9) | Монгол Улсын гарал үүсэлтэй бараа мөн эсэх ³ |
| 1 | | | | | | | | | | Tийм/Үзүй |
| 2 | | | | | | | | | | |
| ... | | | | | | | | | | |
| | | | | | | | | Тендерийн нийт үнэ | | |

*[Итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд,
эсхүл түүнээс эрх олгогдсон этгээдийн нэр,
албан тушаал, гарын үсэг, байгууллагын
тамга, тэмдэг]:*

² ТШЗ-ны 18.6.2-ын дагуу ирүүлсэн баримт бичигт дурдсан барааны гарал үүслийн талаарх мэдээлэлтэй ижил байна.

³ Монгол Улсын гарал үүсэлтэй бараа мөн эсэх гэдэгт “тийм” гэж бөглөсөн бол түүнийг нотлох баримт бичгийг хавсаргана.

Маягт 3

Ижил төстэй бараа нийлүүлсэн гэрээний мэдээлэл

| Гэрээний нэр | Захиалагчийн нэр, хаяг, холбоо барих утас | Төсөвт өртөг | Хугацаа /эхэлсэн, дууссан/ |
|--------------|---|--------------|----------------------------|
| | | | |
| | | | |
| | | | |
| | | | |

Маягт 4

Хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэхээр эрх авсан гэрээний мэдээлэл

| Гэрээний нэр | Захиалагчийн нэр, хаяг, холбоо барих утас | Төсөвт өртөг | Гэрээ эхэлсэн хугацаа | Хүлээгдэж буй гүйцэтгэлийн хувь, мөнгөн дүнгээр | Дуусах хугацаа |
|--------------|---|--------------|-----------------------|---|----------------|
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |

Оролцогчийн нэр: [түншлэлийн гишүүн тус бүр бүрэн дуусгавар болсон гэрээ тус бүрээр бөглөнө].

| | |
|----|---|
| 1. | Захиалагчийн нэр |
| 2. | Гэрээний нэр |
| 3. | Гэрээний дугаар |
| 4. | Гэрээ байгуулсан огноо |
| 5. | Гэрээ дуусгавар болсон огноо |
| 6. | Гэрээний дүн |
| 7. | Гэрээ гүйцэтгэсэн хаяг, байршил |
| | Гэрээнд оролцсон байдал (нэгийг сонгох) <input type="checkbox"/> Үндсэн нийлүүлэгч <input type="checkbox"/> Түншлэлийн гишүүн <input type="checkbox"/> Туслан гүйцэтгэгч |

Маягт 6

Нууцалсан баримт бичиг, мэдээллийн жагсаалт

| | Нууцалсан баримт бичиг, мэдээлэл | Хүний эмзэг мэдээлэлд хамаарах хууль зүйн үндэслэл |
|----|---|---|
| 1. | | |
| 2. | | |
| 3. | | |
| 4. | | |
| 5. | | |

VI БҮЛЭГ. ГЭРЭЭНИЙ НӨХЦӨЛ

Санамж

Захиалагч, түүнээс томилсон үнэлгээний хороо нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (цаашид “хууль” гэх)-ийн дагуу тендер шалгаруулалт зохион байгуулж бараа худалдан авахад энэхүү гэрээний нөхцөлийг боловсруулж ашиглана.

Гэрээний ерөнхий нөхцөл (цаашид “ГЕН” гэх) болон гэрээний тусгай нөхцөл (цаашид “ГТН” гэх), түүнд заасан бусад баримт бичиг нь хоёр талын эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлох баримт бичиг болно. Энэ гэрээ нь захиалагчаас бараа, түүнтэй холбогдох үйлчилгээг худалдан авах харилцааг зохицуулсан жишиг заалтуудыг агуулна. Гэрээний нөхцөлийг боловсруулахад ГЕН-д өөрчлөлт оруулахгүй.

ГТН-ийг тухайн бараа худалдан авах нөхцөлд тохируулан ГЕН-ийн холбогдох зүйл, заалтыг тодруулах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах зорилгоор ашиглана. Гэрээний нөхцөлийг бэлтгэхэд дараахыг анхаарна:

1. ГЕН-ийн аль нэг зүйлд тодорхой мэдээллийг ГТН-д тусгахаар заасан бол холбогдох мэдээллийг ГТН-д заавал оруулна. ГЕН-ийн аль нэг зүйл, заалтыг тухайн бараа худалдан авахад хэрэглэхгүй бол энэ тухай ГТН-д тусгах;
2. Гэрээ баталгаажуулах маягтад шалгарсан оролцогчийн мэдээлэл болон “хамгийн сайн” үнэлэгдсэн тендерийн мэдээллийг тусгах;
3. Гэрээний үнийг тендерийн үнэд залруулга болон хөнгөлөлтийг тооцож, нэг валютад хөрвүүлсний дараах үнээр тогтоох;
4. Нийлүүлэх бараа, дагалдах үйлчилгээний дэлгэрэнгүй тодорхойлолт, зураг зэргийг гэрээнд хавсаргах;
5. ГЕН, ГТН болон холбогдох хавсралтууд нь өөр хоорондоо зөрчилдөөнгүй байх;
6. Гэрээ баталгаажуулах маягтын хаалтан дотор бичсэн жишээ, зааврыг тендер шалгаруулалтын үр дүнд шалгарсан тендерийн нөхцөлд тохирох үг өгүүлбэр, тоо хэмжээ зэргээр тусгана. ГТН-д заасан зарим жишээ, нөхцөлийг зөвхөн санаа өгөх зорилгоор оруулсан ба тухайн гэрээний онцлогийг харгалзан захиалагч эцэслэнэ.
7. Нийтийн албанад нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан гэрээ байгуулах албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхтэй холбогдсон хориглолт, хязгаарлалттай танилцаж, судалсан байх шаардлагатай болохыг анхаарна уу.

ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

НЭГ. ТОДОРХОЙЛОЛТ БА ТАЙЛБАР

Тодорхойлолт

- 1.1. Гэрээнд хэрэглэсэн үг, хэллэг, илэрхийлэл нь дор дурдсан утгыг агуулна:
 - 1.1.1. “Бараа” гэж Нийлүүлэгчээс Захиалагчид нийлүүлэхээр Тендерт ирүүлсэн хөрөнгийг;
 - 1.1.2. “Дагалдах үйлчилгээ” гэж бараа нийлүүлэхтэй холбоотой угсралт, суурилуулалт, сургалт, засвар үйлчилгээ болон Нийлүүлэгчийн үзүүлэх бусад үйлчилгээг;
 - 1.1.3. “Захиалагч” гэж Гэрээ баталгаажуулах маягтад нэрлэсэн этгээдийг;
 - 1.1.4. “Нийлүүлэгч” гэж гэрээ байгуулах эрх авсан бөгөөд Гэрээ баталгаажуулах маягтад нэрлэсэн этгээдийг;
 - 1.1.5. “Талууд” гэж Захиалагч болон Нийлүүлэгчийг хамтад нэрлэснийг;
 - 1.1.6. “Хууль” гэж Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг;
 - 1.1.7. “Бараа нийлүүлэх нөхцөл” гэж Захиалагчийн техникийн тодорхойлолтод нийцүүлж Тендерт тусгасан бараа бэлтгэх, нийлүүлэх, дагалдах үйлчилгээ үзүүлэх нөхцөлийг ойлгоно. Тендерт тусгайлан заагаагүй бараа нийлүүлэх нөхцөлийг Техникийн тодорхойлолтод тусгаснаар ойлгоно. Хуулийн 30.2, 34.2-т зааснаар хэлэлцээ хийсэн тохиролцоо нь Гэрээнд тусгагдсан бол Бараа нийлүүлэх нөхцөлийн нэг хэсэг болно.
 - 1.1.8. “Бараа нийлүүлэх газар” гэж барааг хүлээлгэн өгөх болон дагалдах үйлчилгээ үзүүлэх газрыг;
 - 1.1.9. “Доголдол” гэж нийлүүлсэн бараа, дагалдах үйлчилгээний барааны шинж байдал, чанар тоо хэмжээ нь Нийлүүлэгчийн ирүүлсэн тендерээс зөрүүтэй байхыг;
 - 1.1.10. “Баталгаат хугацаа” гэж нийлүүлсэн барааг зориулалтын дагуу ердийн байдлаар ашиглах явцад бараанд илэрсэн доголдлыг нийлүүлэгч хариуцах хугацааг;
 - 1.1.11. “Гомдлын шаардлага гаргах хугацаа” гэж гэрээгээр баталгаат хугацаа тогтоогоогүй бол Захиалагчаас доголдолтой холбогдуулж Нийлүүлэгчид шаардлага гаргах хугацааг;
 - 1.1.12. “Захиалагчийн төлөөлөгч” гэж Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, гэрээг цуцлах, гэрээнээс татгалзахаас бусад Гэрээг хэрэгжүүлэхтэй холбоотой асуудлаар Нийлүүлэгчтэй

- харилцах, хяналтыг хэрэгжүүлэх эрхтэй Захиалагчаас томилогдсон этгээдийг;
- 1.1.13. “Нийлүүлэгчийн төлөөлөгч” гэж Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, гэрээг цуцлах, гэрээнээс татгалзахаас бусад Гэрээг хэрэгжүүлэхтэй холбоотой асуудлаар Захиалагчтай харилцах эрхтэй Нийлүүлэгчээс томилогдсон этгээдийг;
- 1.1.14. “Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал” гэж талуудын хараа хяналтаас гадуур болсон, урьдчилан таамаглах боломжгүй, гэрээний үүргийг гүйцэтгэх боломжгүй болгох байгалийн гамшиг, Төрийн эрх бүхий байгууллага, албан тушаалтны үйлдэл /эс үйлдэхүй/, гоц халдварт, олон улсын хөл хориот өвчин, цар тахлын улмаас бүх нийтийн хорио тогтоосон нөхцөл байдал бий болохыг ойлгоно.
- Гэрээний тайлбар
- 1.2. Гэрээг тайлбарлах, хэрэглэхэд дараах журмыг баримтална:
- 1.2.1. Ганц тоог илэрхийлсэн үг нь олон тоог, олон тоогоор илэрхийлсэн үг нь ганц тоог хамааруулж болно.
- 1.2.2. Бүлэг болон зүйлийн гарчиг нь гэрээг системчлэх зорилготой бөгөөд гэрээг тайлбарлахад ашиглахгүй.
- 1.2.3. Зүйл, заалт, үг, өгүүлбэрийг энэ гэрээнд заасан нэр томьёог үндэслэн тайлбарлах бөгөөд гэрээнд тайлбарлаагүй тохиолдолд гэрээний агуулгад нийцүүлэн тайлбарлана. Хэрэв гэрээний агуулгад үндэслэн тайлбарлах боломжгүй тохиолдолд Иргэний хуульд заасан журмыг баримтлан тайлбарлана.
- 1.2.4. Ерөнхий нөхцөл болон тусгай нөхцөл хоорондоо зөрчилдсөн тохиолдолд тусгай нөхцөлийг баримтална.
- 1.2.5. Гэрээний хэрэгжилтийн явцад харилцах хэл нь Монгол хэл байх бөгөөд гэрээг өөр хэл дээр байгуулснаас хувиуд нь хоорондоо зөрчилдсөн тохиолдолд Монгол хэл дээрх хувийг баримтална.
- ХОЁР. НИЙЛҮҮЛЭГЧ**
- Бараа нийлүүлэх
- 2.1 Нийлүүлэгч нь гэрээнд заасан бараа нийлүүлэх нөхцөл, нийлүүлэлтийн хуваарь, ГТН-д заасан хугацааг баримтлан Бараа нийлүүлэх, Дагалдах үйлчилгээ үзүүлэх үүрэгтэй.
- 2.2 Нийлүүлэгч гэрээний дагуу Дагалдах үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай ажилтан, тоног төхөөрөмж зэргийг Тендерт санал болгосноор оролцуулах ба гүйцэтгэлийн явцад эдгээрт өөрчлөлт орох зайлшгүй

| | |
|---|---|
| | шаардлагатай нөхцөл үүссэн бол Захиалагчаас урьдчилан бичгээр зөвшөөрөл авна. |
| | 2.3 ГЕН-ийн 2.2-т заасны дагуу өөрчлөлт оруулсан тохиолдолд Захиалагчийн шаардсан техникийн чадавх, туршлагын шаардлагыг хангасан байна. |
| | 2.4 Нийлүүлэгч нь Барааг нийлүүлэхэд зайлшгүй шаардлагатай баримт бичиг, бусад зүйлийг гаргуулахыг хүссэн тохиолдолд Захиалагч ердийн боломжит хугацаанд гаргаж өгнө. |
| Бараа нийлүүлэх газар | 2.5 Бараа нийлүүлэх болон Дагалдах үйлчилгээ үзүүлэх газрыг ГТН-д заана. |
| Бараа нийлүүлэх хугацаа, түүнийг сунгах | 2.6 Бараа нийлүүлэх хугацааг нийлүүлэлтийн хуваарийг үндэслэн ГТН-д заана. |
| | 2.7 Нийлүүлэгч дараах нөхцөл бий болсон тохиолдолд бараа нийлүүлэлтийн хугацааг сунгах тухай хүсэлт гаргаж болно: |
| | 2.7.1 Захиалагч ГЕН-ийн 2.4-д заасан үүргээ зохих ёсоор гүйцэтгээгүй; |
| | 2.7.2 Барааг гэрээнд заасан хугацаанд нийлүүлэх боломжгүйд хүргэсэн Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал бий болсон. |
| Барааг хүлээлгэн өгөх | 2.8 Захиалагч ГЕН-ийн 2.7-д заасан нөхцөлийн аль нэг нь бүрдсэн гэж үзвэл Нийлүүлэгчийн хүсэлтийг үндэслэн хугацааг сунгаж болно. |
| | 2.9 ГЕН-ийн 2.7.2-т заасан нөхцөл байдал үүссэн болохыг Нийлүүлэгч нотлох үүрэгтэй. |
| | 2.10 Нийлүүлэгч нь Барааг ГТН-д заасан нөхцөлөөр хүлээлгэн өгч, дагалдах үйлчилгээг бүрэн үзүүлж, баримт (хүлээлцсэн акт) үйлдэнэ. |
| | 2.11 Нийлүүлэгч нь барааг хүлээлгэн өгч, дагалдах үйлчилгээг үзүүлснээр Захиалагчид барааны өмчлөх эрх шилжинэ. |
| Барааны гарал үүслийн улс | 2.12 Гэрээний дагуу нийлүүлэх Бараа нь Тендерт заасан улсын гарал үүсэлтэй байна. |
| | 2.13 Нийлүүлэгчийн Тендерийг шалгаруулахад түүнд давуу эрх олгосон бол үнэлгээний явцад үнийг нь хийсвэрээр бууруулж тооцсон аливаа бараа нь заавал Монгол Улсын гарал үүсэлтэй бараа байна. |
| Баглаа боодол | 2.14 Нийлүүлэгч барааг ГЕН-ийн 2.5-д заасан газар хүртэл тээвэрлэх явцад гэмтэх, муудах, дутах зэрэг доголдлоос урьдчилан сэргийлэх сав, баглаа боодлыг ГТН-д заасны дагуу хангана. |
| | 2.15 Сав, баглаа боодол, түүний хаягдал нь хүрээлэн буй орчинд учруулах сөрөг нөлөөллийг хамгийн бага байхаар сонгоно. Сав, баглаа боодолд хууль тогтоомжоор хориглосон материал ашиглахыг хориглоно. |

| | | |
|-----------------------|-------------------------|--|
| | 2.16 | Нийлүүлэгч баглаа боодол, түүний дотор, гадна талд тэмдэглэгээ хийх, баримт бичгийг бэлтгэхдээ ГТН-д заасан шаардлага болон Захиалагчийн тухайн үед өгөх зааварчилгааг мөрдөнө. |
| Худалдааны нөхцөл | 2.17 | Гэрээнд Худалдааны нөхцөл (Incoterms)-ийг хэрэглэх бол тендерийн өгөгдлийн хүснэгтийн ТШЗ-ны 20.6-д заасан нөхцөлийг ГТН-д тусгана. |
| | 2.18 | ГТН-д заагаагүй бол Incoterms 2020 Delivery Duty Paid /DDP/ нөхцөлөөр бараа нийлүүлэлтийн хуваарьт дурдсан газарт хүргүүлэхээр хэрэглэнэ. |
| Гүйцэтгэлийн баталгаа | 2.19 | Гүйцэтгэлийн баталгаа гаргуулахаар Өгөгдлийн хүснэгтэд заасан бол Нийлүүлэгч нь тухайн төсвийн жилд санхүүжих дүнгийн З хувийн үнийн дүнтэй гүйцэтгэлийн баталгааг холбогдох маягтын дагуу захиалагчаас шаардсан хугацааны дотор ирүүлнэ. Төсвийн жил дамжин хэрэгжих гэрээний гүйцэтгэлийн баталгааг Нийлүүлэгч жил бүр шинэчлэн ирүүлнэ. |
| | 2.20 | Захиалагч дараах нөхцөл бий болсон тохиолдолд үүргийн гүйцэтгэлийг Нийлүүлэгчийн Гүйцэтгэлийн баталгаагаар үл маргах журмаар хангулна: |
| | 2.20.1 | Нийлүүлэгч гэрээгээр хүлээсэн үүргээ аливаа шалтгааны улмаас гүйцэтгээгүй; |
| | 2.20.2 | Нийлүүлэгч гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор гүйцэтгээгүй; |
| | 2.20.3 | Нийлүүлэгч гэрээгээр хүлээсэн үүргээ гүйцэтгэх боломжгүй болсон. |
| | 2.21 | Захиалагч гүйцэтгэлийн баталгаагаар үүргийн гүйцэтгэлийг хангулсан нь Нийлүүлэгчээс алданги, хохирол шаардах эрхийг хязгаарлахгүй. |
| | 2.22 | ГЕН-ийн 2.8-д заасны дагуу хугацаа сунгагдсан тохиолдолд Нийлүүлэгч гүйцэтгэлийн баталгааг мөн хугацаагаар сунгуулна. |
| | 2.23 | Чанарын баталгаа шаардсан тохиолдолд ГЕН-ийн 4.11-д заасан Чанарын баталгаа гаргасан тохиолдолд Гүйцэтгэлийг баталгааг чөлөөлнө. |
| | ГУРАВ. ЗАХИАЛАГЧ | |
| Барааг хүлээн авах | 3.1 | Захиалагч нь барааг хүлээн авч, хүлээлцсэн баримт (хүлээлцсэн акт) үйлдэнэ. |
| Шалгалт, туршилт | 3.2 | Нийлүүлэх бараа, дагалдах үйлчилгээ, үйлдвэрлэлийн үйл явц Нийлүүлэгчийн ирүүлсэн тендерт нийцэж буй эсэхийг хянах зорилгоор Захиалагч шалгалт, туршилт явуулах эрхтэй. Шалгалт, туршилт хийх хугацаа, журмын талаар Захиалагч нь Нийлүүлэгчид бичгээр урьдчилан мэдэгдэнэ. |
| | 3.3 | Шалгалт, туршилтын явцыг тэмдэглэл үйлдэн талууд баталгаажуулах бөгөөд бараа, дагалдах үйлчилгээ доголдолтой тохиолдолд Захиалагч доголдлыг арилгуулахаар Нийлүүлэгчид мэдэгдэл хүргүүлнэ. |

- | | |
|-----------------------------------|--|
| | <p>3.4 ГЕН-ийн 3.3-т заасан мэдэгдлийн дагуу Нийлүүлэгч барааны доголдлыг арилгах арга хэмжээ авна.</p> <p>3.5 Барааг хүлээн авахаас өмнө Захиалагч шалгасан, туршсан байх нь хүлээн авах үед түүнийг дахин шалгах, турших болон шаардлагатай тохиолдолд барааг хүлээн авахаас татгалзах, доголдолтой холбогдуулж шаардлага гаргах Захиалагчийн эрхийг хязгаарлахгүй.</p> <p>3.6 Шалгалт, туршилт хийхтэй холбоотой аливаа зардлыг Нийлүүлэгч хариуцна.</p> |
| Гэрээний үнэ | <p>3.7 Гэрээний үнийг Гэрээ баталгаажуулах маягтад заана.</p> <p>3.8 Гэрээний үнэд хуулийн 40.4-д заасан үндэслэлээр тохируулга хийх эсэх, тохируулга хийх бол аргачлалыг ГТН-д заана.</p> |
| Төлбөр төлөх | <p>3.9 Захиалагч нь төлбөрийн хүсэлт, нэхэмжлэхийг үндэслэн ГТН-д заасан хугацаанд төлбөрийг Нийлүүлэгчид төлнө.</p> <p>3.10 Нийлүүлэгчийн хүсэлтээр Захиалагч Бараа нийлүүлэх хугацааг ГЕН-ийн 2.8-д заасны дагуу сунгасан бол сунгагдсан хугацаагаар Захиалагчийн төлбөр төлөх хугацааг сунгагдсан гэж үзнэ.</p> <p>3.11 Захиалагч нь гэрээний үүргийг зохих ёсоор гүйцэтгэсэн тухай баримтын хуулбар хувь болон бусад холбогдох баримтыг төлбөрийн хүсэлт, нэхэмжлэхэд хавсаргахыг шаардаж болно.</p> <p>3.12 Захиалагч урьдчилгаа төлбөр төлөхгүй.</p> <p>3.13 ГЕН-ийн 3.8-д заасны дагуу үнэ тохируулж, гэрээний үнэ өөрчлөгдсөн тохиолдолд гэрээнд нэмэлт, өөрчлөлт орсноос хойш өөрчлөгдсөн үнийг баримтална.</p> <p>3.14 Төлбөрийн нэхэмжлэх нь Монгол Улсын Үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр илэрхийлэгдсэн байна.</p> <p>3.15 Захиалагч нь алданги болон бусад төлбөр шаардах эрхтэй бол Нийлүүлэгчид төлөх төлбөрөөс суутгана.</p> |
| Захиалагчийн хүлээх эрсдэл | <p>ДӨРӨВ. ЭРСДЭЛ БА ХАРИУЦЛАГА</p> <p>4.1. Захиалагч дараах эрсдэлийг хариуцна:</p> <p>4.1.1. Барааг захиалагчид шилжүүлснээс хойш бараа нь ГЕН-ийн 1.1.14-д заасан болон бусад байдлаар гэмтсэн, устсан;</p> <p>4.1.2. Нийлүүлэгч Барааг гэрээнд заасан хугацаанд хүлээлгэн өгөх тодорхой үйлдэл хийсэн боловч Захиалагч хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хүлээн аваагүй (доголдолтой бараанд хамаarahгүй) байх хугацаанд ГЕН-ийн 1.1.14-д заасан болон бусад байдлаар Бараа гэмтсэн, устсан.</p> |
| Даатгал | <p>4.2. Нийлүүлэгч нь барааг үйлдвэрлэх, тээвэрлэх, хадгалах, хүлээлгэн өгөх үед гарч болох эрсдэлээс хамгаалж ГТН-д заасны дагуу даатгуулж, даатгалын</p> |

| | |
|------------------|--|
| | гэрээ, гэрчилгээний хуулбар хувийг Захиалагчид ирүүлнэ. Даатгалын хураамжийг Нийлүүлэгч хариуцна. |
| Доголдол | <p>4.3. Захиалагч бараа, дагалдах үйлчилгээг шалгаж, илэрсэн зөрчил, доголдлын талаар Нийлүүлэгчид мэдэгдэнэ.</p> <p>4.4. Захиалагч зөрчил, доголдлыг илрүүлэх зорилгоор барааны далд хэсгийг нээх, шалгалт, туршилт хийх эрхтэй.</p> <p>4.5. Захиалагч ГТН-д заасан баталгаат хугацаа эсхүл гомдлын шаардлага гаргах хугацаа дуусахаас өмнө зөрчил, доголдол арилгах тухай мэдэгдлийг нийлүүлэгчид өгнө.</p> <p>4.6. Доголдол арилгах мэдэгдэл өгсөн тухай бур Нийлүүлэгч уг зөрчил, доголдлыг мэдэгдэлд заасан хугацаанд өөрийн зардлаар арилгана.</p> <p>4.7. Нийлүүлэгч зөрчил, доголдлыг мэдэгдэлд заасан хугацаанд арилгаагүй бол Захиалагч өөрийн зардлаар арилгана.</p> <p>4.8. Захиалагчийн гаргасан зардлыг Нийлүүлэгч Захиалагчид үл маргах журмаар төлнө.</p> <p>4.9. Захиалагч нь ГЕН-ийн 4.7-д заасан зардлыг Чанарын баталгаанаас суутгаж болох бөгөөд Чанарын баталгаа хүрэлцээгүй тохиолдолд илүү гарсан зардлыг Нийлүүлэгч нь Захиалагчид үл маргах журмаар төлнө.</p> |
| Чанарын баталгаа | <p>4.10. Бараа, дагалдах үйлчилгээний баталгаат хугацааг ГТН-д заана.</p> <p>4.11. ГТН-д заасан бол чанарын баталгааг хангуулах зорилгоор баталгаат эсхүл гомдлын шаардлага гаргах хугацаанд Чанарын баталгаа гаргуулж болно.</p> <p>4.12. Нийлүүлэгч Чанарын баталгааг хуулийн 43.7-д заасны дагуу баталгаажуулж болно.</p> <p>4.13. ГЕН-ийн 4.12-д заасны дагуу баталгаажуулсан тохиолдолд Захиалагч барьцаалсан мөнгийг баталгаанд заасан дүнтэй тэнцэх хэмжээгээр олгоно.</p> <p>4.14. Баталгаат эсхүл гомдлын шаардлага гаргах хугацаанд Бараанд аливаа доголдол илрээгүй бол Чанарын баталгааг чөлөөлнө.</p> <p>4.15. ГЕН-ийн 4.7-д зааснаар Захиалагч доголдлыг арилгасан бол доголдол арилгахтай холбоотой гарсан зардал, хохирлыг суутгаж, баталгаат эсхүл гомдлын шаардлага гаргах хугацаа дуусмагц үлдсэн мөнгийг Нийлүүлэгчид олгоно.</p> <p>4.16. ГЕН-ийн 4.7-д заасны дагуу доголдлыг арилгасан тохиолдолд баталгаат эсхүл гомдлын шаардлага гаргах хугацаа хэвийн үргэлжилнэ.</p> |
| Алданги | <p>4.17. Нийлүүлэгч нь барааг хуваарийн дагуу буюу гэрээнд заасан хугацаанд нийлүүлээгүй тохиолдолд хугацаа</p> |

| | | | |
|---|---|--|--|
| | хэтэрсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгээр ГТН-д заасан хувь хэмжээгээр алдангийг Захиалагчид төлнө. | | |
| Оюуны өмчийн эрх зөрчих | 4.18. Захиалагч нь төлбөр төлөх үүргээ хугацаандаа гүйцэтгээгүй тохиолдолд хугацаа хэтрүүлсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн ГТН-д заасан хувь хэмжээгээр алдангийг Нийлүүлэгчид төлнө. | | |
| Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал | 4.19. Барааг өмчлөх, эзэмших, ашиглах явцад гуравдагч этгээдийн оюуны өмчийн эрх зөрчигдсөн нь эрх бүхий байгууллагын шийдвэрээр тогтоогдсон бол буруутай тал нь хариуцлагыг хүлээж, холбогдон гарах зардал, хохирлыг арилгана. | 4.20. Барааг гэрээнд заасан хугацаанд нийлүүлэх боломжгүйд хүргэсэн гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал бий болсон тохиолдолд Нийлүүлэгч нь энэ тухай нэн даруй Захиалагчийн төлөөлөгчид бичгээр мэдэгдэнэ. Бичгээр мэдэгдэх нь хугацаа шаардахаар бол ГЕН-ийн 6.10-д заасан хэлбэрээр урьдчилан мэдэгдэж болно. | |
| Үүрэг гүйцэтгүүлэх нэмэлт хугацаа | 4.21. Нийлүүлэгч нь Захиалагчаас зааварчилгаа өгөх хүртэл гэрээг хэрэгжүүлэх боломжит бүх арга замыг хайна. | 4.22. Захиалагч ердийн боломжит хугацаанд зааварчилгаа өгөх бөгөөд талууд харилцан зөвшилцэж гэрээг хэрэгжүүлэх боломжит бүх арга хэмжээг авна. | 4.23. Гэрээг хэрэгжүүлэх Захиалагчийн зааварчилгаа, Нийлүүлэгчийн авсан арга хэмжээ үр дүнд хүрээгүй тохиолдолд Нийлүүлэгч ГЕН-ийн 2.7-д заасан хүсэлт гаргаж болно. |
| Гэрээнээс татгалзах, гэрээг цуцлах үндэслэл | 4.24. Гэрээний нэг тал нь үүргийн зөрчил гаргасан тохиолдолд нөгөө талд үүргийн зөрчлийг арилгах нэмэлт хугацаа тогтоож, мэдэгдэл хүргүүлнэ. Нэмэлт хугацаа нь үүргийг гүйцэтгэх ердийн боломжит хугацаа байна. | 4.25. Иргэний хуулийн 226 дугаар зүйлд заасан үндэслэл бий болсон тохиолдолд эсхүл Нийлүүлэгч ГЕН-ийн 2.13-т заасныг зөрчсөн бол нэмэлт хугацаа тогтоохгүй байж болно. | |
| ТАВ. ГЭРЭЭ ДУУСГАВАР БОЛОХ | | | |
| | 5.1. Захиалагч дараах үндэслэлийн аль нэг нь хангагдсан тохиолдолд гэрээнээс татгалзах эсхүл гэрээг цуцлах эрхтэй: | | |
| | 5.1.1. Нийлүүлэгч гэрээнд заасан хугацаанд үүргээ гүйцэтгээгүй эсхүл зохих ёсоор гүйцэтгээгүйн улмаас Захиалагч үүрэг гүйцэтгэх нэмэлт хугацаа тогтоосон боловч нэмэлт хугацаанд гүйцэтгээгүй; | | |

- | | |
|--|---|
| | <p>5.1.2. Бараа нийлүүлэх хугацаанд Нийлүүлэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хугацаа дуусаж сунгагдаагүй, түдгэлзүүлсэн, хүчингүй болсон;</p> <p>5.1.3. Нийлүүлэгч ГЕН-ийн 6.5-д заасан үүргээ зөрчсөн нь тогтоогдсон.</p> <p>5.1.4. Нийлүүлэгч өөрийн тендерийн давуу эрх тооцуулсан нөхцөлийн дагуу гэрээний үүргийг биелүүлээгүй.</p> |
| | <p>5.2. Нийлүүлэгч тендерт оролцох буюу бараа нийлүүлэх явцдаа авлига өгсөн, запилах гэмт хэрэг үйлдсэн нь шүүх болон эрх бүхий байгууллагын шийдвэрээр тогтоогдсон.</p> <p>5.3. Захиалагч нь төлбөр хийх хугацаа хэтэрсэн тухай мэдэгдлийг хүлээн авснаас хойш тогтоосон хугацаанд төлбөрийг төлөөгүй тохиолдолд Нийлүүлэгч гэрээг цуцалж болно.</p> <p>5.4. Нийлүүлэгч ямар ч тохиолдолд гэрээнээс татгалзах эрхийг хэрэгжүүлэхгүй.</p> |
| Гэрээнээс татгалзах, гэрээг цуцлах мэдэгдэл | <p>5.5. Гэрээнээс татгалзах, гэрээг цуцлах мэдэгдэлд гэрээнээс татгалзах, гэрээг цуцлах болсон үндэслэл, цаашид гэрээг дуусгавар болсонтой холбоотой авах арга хэмжээний тухай тусгасан байна.</p> |
| ЗУРГАА. БУСАД ЗҮЙЛ | |
| Төлөөлөгч | <p>6.1. Талууд өөрийн төлөөлөгчийг томилж, томилсон төлөөлөгчийн мэдээллийг гэрээ баталгаажуулах маягтад заана.</p> <p>6.2. Төлөөлөгчийн мэдээлэлд түүний эцэг (эх)-ийн нэр, өөрийн нэр, албан тушаал, холбоо барих утас (ажлын болон хувийн), цахим шуудангийн хаяг тэмдэглэгдсэн байна.</p> <p>6.3. Гэрээ хэрэгжүүлэх явцад төлөөлөгч солигдсон бол Төлөөлөгч солигдсон тухай болон түүний мэдээллийг агуулсан мэдэгдлийг нөгөө талд бичгээр хүргүүлнэ.</p> <p>6.4. Төлөөлөгч нь төлөөлүүлэгчээс бичгээр олгосон зөвшөөрөлгүйгээр эрх, үүргээ аливаа хэлбэрээр бусдад шилжүүлэхийг хориглоно.</p> |
| Туслан гүйцэтгэгч | <p>6.5. Туслан гүйцэтгэгчээр гүйцэтгүүлж байгаа тохиолдолд Нийлүүлэгчийн ирүүлсэн тендерт зааснаас илүү хувийг туслан гүйцэтгэгчээр гүйцэтгүүлэхгүй байх үүрэгтэй.</p> <p>6.6. Туслан гүйцэтгэгчийн аливаа зөрчлийг (хугацаа хэтрүүлэх, ажлын догоилдол гэх мэт) Нийлүүлэгч хариуцах бөгөөд Туслан гүйцэтгэгч өөрчлөгдсөн тохиолдолд ГЕН-ийн 2.3-д заасан журмыг баримтална.</p> |
| Нууцлал | <p>6.7. Талууд гэрээг хэрэгжүүлэх явцад олж авсан хуулиар тогтоосон болон байгууллагаас нууц гэж нууцалж хамгаалалтад авсан аливаа мэдээллийг нөгөө тал</p> |

| | |
|----------------------------------|---|
| | зөвшөөрсөн эсхүл эрх бүхий байгууллага шаардсанаас бусад тохиолдолд гуравдагч этгээдэд задруулахгүй, дамжуулахгүй, нийтэд ил болгохгүй. |
| Мэдэгдэл | <p>6.8. Талуудын хувьд нууц мэдээллийг нөгөө талдаа ил болгож байгаа тохиолдолд нууц гэсэн тэмдэглэл хийж, нууцыг задруулахгүй байх мэдэгдлийг хамт өгнө.</p> <p>6.9. Гэрээний үүргийн гүйцэтгэлтэй холбоотой бүх мэдэгдэл (зөвшөөрөл, татгалзал, баталгаа, баталгаажуулалт, нэхэмжлэх, гэрчилгээ, шийдвэр, хүсэлт, захидал үүгээр хязгаарлагдахгүй) нь бичгээр үйлдэгдэнэ.</p> <p>6.10. Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал үүссэн тухай мэдэгдлийг ГЕН-ийн 6.9 -д зааснаас өөр хэлбэрээр мэдэгдэж болох бөгөөд мэдэгдлийг баталгаажуулж бичгээр хүргүүлнэ.</p> <p>6.11. Мэдэгдлийг биечлэн хүргүүлэх эсхүл баталгаат шуудангаар гэрээ баталгаажуулах маягтад заасан Төлөөлөгчийн хаягаар илгээнэ.</p> <p>6.12. Дараах тохиолдолд мэдэгдлийг хүлээн авсанд тооцно:</p> <p>6.12.1. баталгаат шуудангаар илгээсэн тохиолдолд шууданд хийсэн өдрөөр, төлбөр төлсөн баримтыг үндэслэн;</p> <p>6.12.2. биечлэн хүргүүлсэн мэдэгдлийг нөгөө талын төлөөлөх эрх бүхий этгээд хүлээн авсан огноогоор, тэмдэглэлийг үндэслэн.</p> <p>6.13. Аль нэг тал нь ажлын газрын хаяг, утас, шуудангийн хаягаа сольсон тохиолдолд нөгөө талдаа нэн даруй бичгээр мэдэгдэнэ.</p> <p>6.14. ГЕН-ийн 6.13-д заасан үүргээ биелүүлээгүйгээс үүсэх үр дагаврыг мэдэгдээгүй тал хариуцна.</p> <p>6.15. Дараах тохиолдолд гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулна:</p> <p>6.15.1. ГЕН-ийн 2.8-т заасны дагуу хугацаа сунгагдсан;</p> <p>6.15.2. үнийн тохируулга хийсэн.</p> <p>6.16. Гэрээний нэмэлт, өөрчлөлтөд талуудын эрх бүхий төлөөлөгч гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар хүчин төгөлдөр болно.</p> <p>6.17. ГЕН-ийн 6.15-д зааснаас бусад тохиолдолд гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулахгүй.</p> <p>6.18. Гэрээг биелүүлэхтэй холбогдон гарсан аливаа санал зөрөлдөөн, маргааныг талууд зөвшилцөх замаар шийдвэрлэнэ.</p> <p>6.19. Талууд зөвшилцөн, шийдвэрлэж эс чадвал Монгол улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.</p> |
| Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах | |
| Маргаан шийдвэрлэх | |

ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

| | |
|------------------|---|
| ГЕН 2.5. | <p>Бараа нийлүүлэх газар:</p> <p>Улсын хоёрдугаар төв эмнэлгийн ҮОЭТ-н В1 давхарын нөөцийн хэсэг</p> |
| ГЕН 2.6. | <p>Бараа нийлүүлэх хугацаа:</p> <ul style="list-style-type: none"> • 2024 оны ... сарын ...-ны өдрөөс 2025 оны ... сарын ...-ний өдрийг хүртэл • Онцгой яаралтай тохиолдолд тусlamж үйлчилгээнд нэн шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгслийг ажлын цагаас үл хамааран 2 тал харилцан тохиролцож захиална, нийлүүлнэ. • Бараа нийлүүлэгчийн хуваарьт захиалагчийн хүсэлтээр өөрчлөлт оруулж болно. <p>Барааг үе шаттай нийлүүлэх бол үе шатны хугацаа: Нийлүүлэлтийн хуваарийн дагуу сар бүрийн 1-3 -ны хооронд, ажлын цагаар -8⁰⁰-15³⁰</p> |
| ГЕН 2.10. | <p>Бараа хүлээлгэн өгөх нөхцөл:</p> <ul style="list-style-type: none"> • Хуваарь болон захиалгын дагуу эд хариуцагчид эвдрэл гэмтэл, сав баглаа боодол бүрэн бүтэн, хадгалалтын горим алдагдаагүй байх. <p>Бараанд холбогдох баримт бичиг:</p> <ul style="list-style-type: none"> • Сар бүрийн татан авалтыг эд хариуцсан эм зүйч, тооцооны нягтлан бодогч нэхэмжлэлийн хамт, хүлээлгэн өгч акт үйлдэнэ. • Тендерт шалгарсан тохиолдол дээжид ирүүлсэн бараа бүтээгдэхүүний техникийн тодорхойлолтод нийцсэн барааг тогтмол нийлүүлэх, техникийн тодорхойлолтой зөрсөн, гэмтэлтэй бараа тохиолдолд сольж өгөх тухай албан бичиг ирүүлэх • Ариутгал халдвартгүйтлийн бодисын мэргэжлийн хяналтын дүгнэлт, улсын бүртгэлийн гэрчилгээ <p>Угсралт, суурилуулах:</p> <p>Угсарч, зөөж, суурилуулах шаардлагатай барааны тухайд нийлүүлэгч энэ үүргийг гүйцэтгэгч зааварчилгаа өгөх. Зарлагын баримт, нэхэмжлэх нь QR кодтой байна</p> |
| ГЕН 2.14. | <p>Баглаа, боодол: Шаардана.</p> <ul style="list-style-type: none"> • Нийлүүлэх барааг бүтээгдэхүүнийг стандартын дагуу ирүүлнэ. • Хагарсан, асгарсан, баглаа боодол болон хадгалалтын горим алдагдсан барааг хүлээн авахгүй. • Хадгалалт болон тээвэрлэлтийн онцгой нөхцөл шаарддаг эм эмнэлгийн хэрэгслийг үйлдээрлэгчийн заалтын дагуух нөхцлийг ханган ирүүлэх, түүнийг нотлох бичиг баримтыг ирүүлэх • Өндөр эрсдэлт эмиийн жагсаалтад орсон, ижил харагддаг |

| | |
|-----------|--|
| | <p>болон дуудагддаг эмүүдэд таних тэмдэг нааж ирүүлэх, сав баглаа боодлыг ялгахуйц тэмдэг тэмдэглэгээ дагалдуулан нааж ирүүлэх</p> <ul style="list-style-type: none"> • Эм эмнэлгийн хэрэгслийг тээвэрлэн ирүүлэхдээ барааг хүргэх эцсийн цэгт ачих, буулгах хангалттай төхөөрөмж, хүн хүчиний нөөцтэй байх • Гэмтэлтэй барааг солих хугацаа: 14 хоногийн дотор <p>Баглаа, боодлын шаардлага:</p> <ul style="list-style-type: none"> • Баглаа боодол нь тээвэрлэлтийн үеийн нөхцөл, тээвэрлэлт болон ил хадгалалтын үеийн халуун, хүйтэн, хур тунадас болон бусад бүх нөхцөлийг хангалттай тэсвэрлэхээр байна. • Баглаа, боодлын хэмжээ, жинг сонгоходо барааг хүргэх эцсийн цэгийн алслагдсан байдал, тээвэрлэлтийн цэг бүрд ачих, буулгах хангалттай төхөөрөмж байгаа эсэх зэрэг хүчин зүйлсийг харгалзсан байна <p>Тэсэрч дэлбэрэх болон химиийн хортой болон аюултай эмийн бодисыг тээвэрлэхдээ аюулгүй ажиллагааны горимыг хэрэгжүүлэн, хагарч гэмтээгүй, асгарсан, хий алдсан байдалгүй, стандартын дагуу тээвэрлэн, хүргэж хүлээлцэнэ</p> |
| ГЕН 2.17. | Худалдааны нөхцөл: Үгүй |
| ГЕН 3.8. | <p>Үнийн тохируулга хийх аргачлал: Үнэ тохируулахгүй, тогтмол байх</p> <p>“Ажиллах хүч болон материалын үнийн өөрчлөлтийг тусгах зорилгоор гэрээний хэрэгжилтийн явцад нийлүүлэгчид төлөх үнийг дараах томьёог ашиглан тохируулна:</p> $\Delta P = P_0 (a + b \underline{L}_1 + c \underline{M}_1) - P_0$ $L_0 \quad M_0$ <p>Үүнд:</p> <p>ΔP-нийлүүлэгчид төлөх нэмэгдэл үнэ</p> <p>P_0-гэрээний үндсэн үнэ;</p> <p>a -гэрээний үнэд шингэсэн ашиг, захиргааны зардлын тогтмол дун. Ихэнх тохиолдолд 5-15 хувийн хооронд хэлбэлздэг;</p> <p>b -гэрээний үнэд ажиллах хүчиний эзлэх хувь;</p> <p>c -гэрээний үнэд материалын эзлэх хувь;</p> <p>L_0-гарал үүслийн улсын холбогдох салбарын ажиллах хүчиний өдрийн индекс;</p> <p>L_0, L_1 -гарал үүслийн улсад мөрдөгдөж буй холбогдох салбарын ажиллах хүчиний суурь өдрийн болон үнэ тохируулах өдрийн индекс;</p> <p>M_1, M_0-гарал үүслийн улсад мөрдөгдөж буй үндсэн барааны суурь өдрийн болон үнэ тохируулах өдрийн индекс.</p> <p>[захиалаагч a, b, c илтгэлциүүрүүдийг тендер шалгаруулалтын баримт бичигт заана. Энэ гурван итгэлциүүрийн нийлбэр дун аль ч тохиолдолд нэг (1) байна.]</p> <p>Тендерт оролцогч индексийн эх үүсвэр болон суурь өдрийн индексийг өөрийн тендерт зааж өгнө.</p> |

| | |
|-----------------|--|
| | <p>Суурь өдөр нь тендер зарласан өдөр байна.</p> <p>Үнэ тохируулах өдөр нь барааг тээвэрлэхээс [тоо бичих]⁴ долоо хоногийн өмнөх өдөр байна (үүнийг үйлдвэрлэх явцын дунд үе гэж ойлгоно).</p> <p>Дараах нөхцөл байдал үүссэн тохиолдолд талууд үнийг тохируулах санал гаргах эрхтэй. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> Гэрээний суурь үнэ [тоо бичих]⁵ хувиас илүү өсөх, эсхүл буурахаар бол үнийг тохируулна. Гэрээг сунгах албан бичигт онцгойлон өөрөөр заагаагүй бол барааг нийлуулэх анхны хуваариас хоцорч нийлуулсэн хугацаанд үниийн тохируулга хийхгүй. Нийлуулэгчээс шалтгаалан хоцорсон хугацаанд үниийн тохируулга хийхгүй. Гэхдээ гэрээний үнэ буурах үниийн тохируулгыг захиалагч эдгээр хугацаанд хийж болно. <p>Гэрээний үнийн /Р0/ валют, ажиллах хүч болон материалын индекс нь гарал үүслийн улсын валютаас өөр байх тохиолдолд, гэрээний үнийн тохируулалт буруу хийгдэхээс урьдчилан сэргийлж, залруулах итгэлцүүрийг ашиглана. Залруулах итгэлцүүр нь тус хоёр валютын суурь өдөр болон үнэ тохируулах өдрийн ханшны харьцаа байна.</p> |
| ГЕН 3.9. | <p>Төлбөр төлөх хугацаа: Гэрээний дагуу гүйцэтгэгчид хийх төлбөрийг дараах нөхцөлөөр хийнэ.</p> <ul style="list-style-type: none"> Монгол улсын гаднаас санал болгосон барааны төлбөр: Гадаад валютаар хийх төлбөр нь [гэрээний үнийн валютыг оруулах]-аар дараах байдлаар төлөгднө: <ol style="list-style-type: none"> Урьдчилгаа төлбөр: Хийхгүй Бараа ачигдсаны дараа төлөх төлбөр: Хийхгүй Барааг хүлээн авч гүйцэтгэл гаражад төлөх: 100% <p>Төгрөгөөр хийх төлбөр нь нэхэмжлэх (Захиалагчийн нэр, хаягийг бичиж, барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан, гарын үсэг, тамга тэмдгээр баталгаажуулсан байна) болон захиалагчийн бараа хүлээн авсан тухай акт ирснээс хойш 45 хоногийн дотор төлөгднө.</p> <p>Монгол улсын дотроос санал болгосон барааны төлбөр:</p> <ul style="list-style-type: none"> Монгол улсын дотроос нийлуулсэн барааны төлбөр: [гэрээний үнийн валютыг оруулах]-аар дараах байдлаар хийгдэнэ. Үүнд: <ol style="list-style-type: none"> Урьдчилгаа төлбөр: Хийхгүй Бараа ачигдсаны дараа төлөх төлбөр: Хийхгүй Барааг хүлээн авч гүйцэтгэл гаражад төлөх: 100% <p>Барааг хүлээн авч, акт үйлдэн, Нийлуулэгчийн нэхэмжлэхийг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 45 хоногийн дотор төлбөрийг төлнө.</p> Энэ гэрээнд хоёр талын нэмэлт өөрчлөлт оруулаагүй нөхцөлд эм эмнэлгийн хэрэгсэл тасалдуулахгүйгээр нийлуулэлтийг цаг тухайд бүр хийнэ. |
| ГЕН 4.2. | <p>Даатгал:</p> <p>Гэрээ нь СИР үнэд үндэслэсэн тохиолдолд даатгал нь “агуулахаас агуулахад” дайн болон ажил хаялтыг оруулсан “бүх эрсдэл” нөхцөлтэй, СИР үнийн 110%-ийн дүнтэй байна.</p> |

⁴Захиалагч шаардлагатай долоо хоногийн тоог заана.

⁵Арван таван (15) хувийг зүй зохистой хэмжээ гэж үзнэ.

| | |
|------------------|--|
| ГЕН 4.10. | Баталгаат хугацаа: Гэрээний дагуу нийлүүлэгдэх үед эм, эмнэлгийн хэрэгсэл нь 1 жилээс дээш хадгалалтын хугацаатай байх ба эмнэлгийн хэрэгслийн хувьд хадгалалтын хугацааны (5/6) нь өнгөрөөгүй байна. |
| ГЕН 4.17. | Нийлүүлэгчийн төлөх алданги: Алданги тооцох эсэх: “ <i>Тийм</i> ” Алдангийн хувь: хоног тутамд 0.05 хувь |
| ГЕН 4.18. | Захиалагчийн төлөх алданги: Алданги тооцох эсэх: “ <i>Тийм</i> ” Алдангийн хувь: хоног тутамд 0.05 хувь |

ГЭРЭЭ БАТАЛГААЖУУЛАХ МАЯГТ

[Тендер шалгаруулалтын нэрийг бичих] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалтын дугаарыг бичих]

..... хот/аймаг

Нэг талаас [захиалагчийн нэрийг бичих] (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас [нийлүүлэгчийн нэрийг бичих] (цаашид “нийлүүлэгч” гэх) нь Нийлүүлэгчийн ирүүлсэн тендерийг хүлээн зөвшөөрч энэхүү гэрээг дараах нөхцөлөөр байгуулав.

Энэхүү гэрээ нь Захиалагч болон Нийлүүлэгчийн хооронд бараа нийлүүлэх, дагалдах үйлчилгээ үзүүлэх (цаашид хамтад нь “Бараа” гэх) болон үнэ төлөхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулна.

1. Энэ гэрээний дагуу нийлүүлэх Барааны үнэ нь [гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэлд заасан үнийн дунг тоогоор болон үсгээр бичих] төгрөг (цаашид “гэрээний үнэ” гэх) байна. Гэрээний үнэ нь санхүүжилтийн дээд хэмжээ байна.
2. Гэрээний үнийг Нийлүүлэгч [Нийлүүлэгчийн нэрийг бичих]-ийн харилцах [Банкны нэрийг бичих] банкны [дансны дугаар бичих] дугаар дансанд шилжүүлнэ.
3. Доор дурдсан баримт бичиг нь цаашид гэрээний хэсэг болно. (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:
 - 3.1. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
 - 3.2. Нийлүүлэгч тендер илгээсэн маягт;
 - 3.3. Гэрээний тусгай нөхцөл;
 - 3.4. Гэрээний ерөнхий нөхцөл;
 - 3.5. Гүйцэтгэлийн баталгаа;
 - 3.6. Техникийн тодорхойлолт;
 - 3.7. Бараа нийлүүлэлтийн хуваарь.
4. Гэрээний хэрэгжилттэй холбоотой асуудлаар талуудыг дараах эрх бүхий этгээдүүд төлөөлнө. Үүнд:
 - 4.1. Захиалагчийн төлөөлөгчийн мэдээлэл
Эцэг/эх-ийн нэр:
Нэр:
Албан тушаал:
Ажлын утас:
Гар утас:
Цахим шуудан:
 - 4.2. Нийлүүлэгчийн төлөөлөгчийн мэдээлэл
Эцэг/эх-ийн нэр:
Нэр:
Албан тушаал:
Ажлын утас:
Гар утас:
Цахим шуудан:

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]

[Гарын үсэг] _____

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]

[Гарын үсэг] _____

ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЗАРЛАЛ

Огноо: **2024 оны 05 дугаар сарын 08**

Тендер шалгаруулалтын төрөл: **Бараа**

Тендер шалгаруулалтын нэр: **Үндсэн тусlamж үйлчилгээнд
шаардлагатай Өндөр өртөгтэй эм,
эмнэлгийн хэрэгсэл худалдан авах
тендер**

Тендер шалгаруулалтын дугаар: **УХТЭ/20240102002**

Нийт төсөвт өртөг: **8,500,000,000**

Тендер шалгаруулалтын арга: **Нээлттэй**

- Улсын хоёрдугаар төв эмнэлэг** нь тендер шалгаруулалтын баримт бичигт заасан шаардлага, шалгуур үзүүлэлт хангасан аж ахуй эрхлэгчийг тендер ирүүлэхийг урьж байна.
- Тендер шалгаруулалт нь дараах багцуудаас бүрдэнэ:

| № | Багцын нэрс | Багцын нийт дун |
|----|--|-----------------|
| 1 | Багц 1. Дурангийн мэс заслын хэрэгсэл/ троокар/ | 139,615,000 |
| 2 | Багц 2. Дурангийн мэс заслын хэрэгсэл-1 | 26,758,500 |
| 3 | Багц 3. Мэс заслын автомат клип | 7,833,000 |
| 4 | Багц 4. Дурангийн мэс заслын хэрэгсэл-2 | 73,086,640 |
| 5 | Багц 5. Биполяр болон хэт авиан энергиэр эдийг түлж тайрах хэрэгсэл | 132,000,000 |
| 6 | Багц 6. Хэт авиан эдийг түлж тайрах гар | 68,530,000 |
| 7 | Багц 7. Мэс заслын оёгч-1 | 97,790,000 |
| 8 | Багц 8. Мэс заслын оёгч-2 | 44,690,000 |
| 9 | Багц 9. Мэс заслын оёгч-3 | 172,875,000 |
| 10 | Багц 10. Өндөр давтамжаар түлж тайрах нэг удаагийн гар | 202,400,000 |
| 11 | Багц 11. Мэс заслын цус тогтоогч хэрэгсэл -ивэрхий | 70,416,500 |
| 12 | Багц 12. Ивэрхийн цавууны багц | 35,000,000 |
| 13 | Багц 13. Клипний багц | 28,004,900 |
| 14 | Багц 14. Эмэгтэйчүүдийн мэс засал | 4,128,300 |
| 15 | Багц 15. Эмэгтэйчүүдийн биполяраар судас болон эдийг түлж тайрах гар | 43,891,386 |
| 16 | Багц 16. Эмэгтэйчүүдийн багц | 12,750,000 |
| 17 | Багц 17. Урологи Хармоник | 124,078,878 |
| 18 | Багц 18 Урологи-1 | 6,050,000 |
| 19 | Багц 19. Зүсэгч электрод биполяр | 51,600,000 |
| 20 | Багц 20. Мэдрэлийн судасны оношлогоо болон эмчилгээний хэрэгсэл | 1,433,090,000 |
| 21 | Багц 21. Мэдрэлийн судасны оношлогоо болон эмчилгээний хэрэгсэл 3 | 220,850,000 |
| 22 | Багц 22. Цөсний замын болон бусад гуурс байрлуулах хэрэгсэл | 16,775,000 |
| 23 | Багц 23. Элэгний ангиографийн оношлогоо эмчилгээний хэрэгсэл | 767,175,000 |
| 24 | Багц 24. TIPS set | 13,926,300 |

| | | |
|----|--|-------------|
| 25 | Багц 25. Хэвлийн хөндийн оношлогоо эмчилгээний хэрэгсэл | 219,450,000 |
| 26 | Багц 26. Судас бөглөгч | 128,500,000 |
| 27 | Багц 27. Судас бөглөгч цавуу-1 | 3,465,000 |
| 28 | Багц 28. Судас бөглөгч цавуу-2 | 7,420,000 |
| 29 | Багц 29. Ангиографийн нэг удаагийн хэрэгсэл | 17,250,000 |
| 30 | Багц 30. Иод агуулсан тосон сууртай бөглөгч бодис | 450,000,000 |
| 31 | Багц 31. Өндөр давтамжит түлэх эмчилгээний зүү | 220,000,000 |
| 32 | Багц 32. Хөлдөөх аблаци эмчилгээний зүү | 25,900,000 |
| 33 | Багц 33. Захын судасны оношлогоо болон эмчилгээний хэрэгсэл | 79,357,700 |
| 34 | Багц 34. Пейсмекер -1 | 122,373,900 |
| 35 | Багц 35. Зүрхний төрөлхийн гажиг | 13,270,000 |
| 36 | Багц 36 Зүрхэн доторх оношилгоо эмчилгээ-2 | 211,110,000 |
| 37 | Багц 37. Пейсмекер-2 | 122,373,900 |
| 38 | Багц 38. Тодосгогч бодис 1 | 77,000,000 |
| 39 | Багц 39. Тодосгогч бодис 2 | 50,596,000 |
| 40 | Багц 40. Өвдөгний хиймэл үе | 769,241,036 |
| 41 | Багц 41. Түнхний хиймэл үе | 200,531,558 |
| 42 | Багц 42. Үений дуран | 63,787,885 |
| 43 | Багц 43. Үндэсний үйлдвэрлэлийн үений дурангийн хагалгааны нэг удаагийн багц | 4,597,362 |
| 44 | Багц 44. Ясны хугарал-1 | 12,725,000 |
| 45 | Багц 45. Ye солих хагалгааны нэг удаагийн хэрэгсэл | 3,161,697 |
| 46 | Багц 46. Үений хагалгааны нэг удаагийн хэрэгсэл | 5,742,000 |
| 47 | Багц 47. Үений дурангийн хусагчийн хошуу | 16,500,000 |
| 48 | Багц 48. Мөрний бүтэн хиймэл үе | 13,000,000 |
| 49 | Багц 49. Антибиотиктой цементийн нэг удаагийн хэв | 2,000,000 |
| 50 | Багц 50. Эрүү нүүрний мэс засал-1 | 11,885,000 |
| 51 | Багц 51. Эрүү нүүрний мэс засал-2 | 5,500,000 |
| 52 | Багц 52. Мэдрэлийн мэс засал-1 | 10,543,500 |
| 53 | Багц 53. Мэдрэлийн мэс засал-2 | 139,589,571 |
| 54 | Багц 54 Нурууны хугаралын иж бурдлийн багц | 13,266,000 |
| 55 | Багц 55. Мэдрэлийн мэс заслын үеийн нэг удаагийн багц | 18,790,992 |
| 56 | Багц 56. Мэдрэлийн мэс засал-2 | 93,824,280 |
| 57 | Багц 57. ЧХХ- Хэрэгсэл-1 | 130,493,000 |
| 58 | Багц 58. ЧХХ- Хэрэгсэл-2 | 92,796,068 |
| 59 | Багц 59. ЧХХ- Суулгац | 462,200,000 |
| 60 | Багц 60. Гемодиализийн эмнэлгийн хэрэгсэл | 2,671,900 |
| 61 | Багц 61. CRRT | 41,770,000 |
| 62 | Багц 62. Гемодиализийн шүүлтүүр | 89,150,000 |
| 63 | Багц 63. Нүдний мэс засал | 34,541,600 |
| 64 | Багц 64. Нүдний мэс засал-2 | 25,353,400 |
| 65 | Багц 65. Хавдрын химийн порт | 15,000,000 |
| 66 | Багц 66. Карбопенемын бүлгийн антибиотик | 60,686,000 |

| | | |
|----|---|---------------|
| 67 | Багц 67. Зүрхэн доторх оношилгоо эмчилгээ-1 | 413,090,000 |
| 68 | Багц 68. Салст болон салстын доод давхаргыг хуулах хэрэгслүүд | 11,800,000 |
| 69 | Багц 69. Хоол боловсруулах замын цус алдалтыг тогтоох, хавдар хөнгөвчлөх хэрэгслүүд | 109,749,600 |
| 70 | Багц 70. Цөс нойр булчирхай сэтгүүрдэх ажилбарын хэрэгслүүд | 80,222,800 |
| 71 | Багц 71. Урологийн мэс заслын нэг удаагийн багц | 4,400,000 |
| | Нийт дүн | 8,499,991,153 |
| | Батлагдсан төсөв | 8,500,000,000 |

Дотоодын үйлдвэрлэлээс доорх барааг худалдан авна.

| | | |
|----|--|-----------|
| 46 | Багц 43. Үндэсний үйлдвэрлэлийн үений дурангийн хагалгааны нэг удаагийн багц | 4,597,362 |
|----|--|-----------|

3. Тендерийг **2024 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн 10 цаг 00 минутаас**—аас өмнө тендер шалгаруулалтын баримт бичигт зааснаар илгээх ба тендерийг **2024 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн 11 цагт 00 минутад -т** нээнэ.
4. Тендерийн хувилбарт саналыг зөвшөөрөх эсэх: “**Зөвшөөрөхгүй**”
5. Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй эсэх: “**Эрхтэй**”
6. Тендер нь түүнийг нээнээс хойш ажлын 30 ба түүнээс дээш өдрийн хугацаанд хүчинтэй байхаар тендерт заана.
7. Тендерийн баталгаа шаардах эсэх: Хуулийн 14.1.2-д заасныг үндэслэн тендерийн баталгаа шаардана. Тендерийн баталгаа шаардсан багцад тендер ирүүлэх оролцогч тендерийн баримт бичигт заасан үнийн дүн бүхий тендерийн баталгааг холбогдох журмын дагуу цахим системээр дамжуулан ирүүлж, тендер илгээнэ. Тендерийн баталгааг ирүүлсэн тохиолдолд оролцогчийн тендерийг нээх болохыг анхаарна уу.
8. Тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж байгаа эсэх: “**Үгүй**”
9. Тендер шалгаруулалтыг хоёр үе шаттай зохион байгуулж байгаа эсэх: “**Үгүй**”
10. Оролцогч цахим системийн үйлчилгээний хураамж төлснөөр тендер илгээх эрхтэй байна.

*Баянзүрх дүүрэг, 3-р хороо, Энхтайваныгудамж-49,
Улсын хоёрдугаар төв эмнэлэг, info@ssch.gov.mn*

Утас: 70150231, 88001862